

МОНГОЛ УЛСЫН ГАЛ УНТРААХ ТЕХНИКИЙН ОЛОН ТӨРӨЛТ СПОРТЫН ТЭМЦЭЭНИЙ ДҮРЭМ

Улаанбаатар хот
2017 он

Монгол улсын гал унтраах техникийн
олон төрөлт спортын тэмцээний дүрэм

Хянан тохиолдуулсан: С.Залуухүү
Я.Ишжамц

Эх бэлтгэсэн: Г.Баттөгс

Эмхтгэсэн: Ц.Нямбаяр
С.Баттөмөр
Ч.Цогтбаяр

Хэвлэлийн хуудас: 2 Х.Х

Цаасны хэмжээ 60х90

ГАРЧИГ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Тэмцээний төрөл
- 1.2. Тэмцээнийг зохион явуулах удирдамж
- 1.3. Амжилтыг үнэлэх
- 1.4. Тэмцээнийг өөрчлөх
- 1.5. Гомдол гаргах

Хоёр. Дасгалжуулагч, тамирчдын эрх, үүрэг

- 2.1. Багийн бүрэлдэхүүний тоо
- 2.2. Тамирчдыг тэмцээнд оролцуулах
- 2.3. Тэмцээнд оролцогчдын эрх, үүрэг
- 2.4. Тамирчдын өмсгөл
- 2.5. Дасгалжуулагч ба багийн ахлагчийн үүрэг, эрх

Гурав. Шүүгчийн бүрэлдэхүүн

- 3.1. Ерөнхий зүйл
- 3.2. Ерөнхий шүүгчийн зөвлөл
- 3.3. Ерөнхий шүүгч
- 3.4. Ерөнхий шүүгчийн орлогч
- 3.5. Ерөнхий нарийн бичгийн дарга
- 3.6. Төрөл хариуцсан ахлах шүүгч
- 3.7. Гарааны шүүгч ба түүний туслахууд
- 3.8. Замын шүүгч
- 3.9. Цагчин шүүгч
- 3.10. Барианы шүүгч
- 3.11. Барианы шүүгчийн нарийн бичиг
- 3.12. Нэвтрүүлэгч шүүгч
- 3.13. Тэмцээний эмч шүүгч

Дөрөв. Тэмцээн явуулах журам

- 4.1. Ерөнхий зүйл
- 4.2. Гараа
- 4.3. Дундын зай

Тав:Тэмцээний төрөл, техник хэрэгсэл, түүнд тавигдах шаардлага,

- 5.1. Довтолгооны шатны тэмцээн Долоо:
- 5.2. 4x100 метрийн буухиа тэмцээн
- 5.3. Саадтай 100 метрийн тэмцээн
- 5.4. Байлдааны тархалтын тэмцээн
- 5.5. Хоёр төрөлтийн тэмцээн

Зургаа. Дээд амжилтыг бүртгэх

- 6.1. Ерөнхий зүйл
- 6.2. Дээд амжилтыг бүртгэх дараалал
- 6.3. Дээд амжилтыг баримтжуулах дараалал

Долоо: Гал унтраах техникийн олон төрөлт спортын цол, зэргийн нэгдсэн ангиллын норм /хүснэгт/

Найм: Хөтлөгдөх баримт бичиг /Хавсралтаар/

Хавсралт №1

Тэмцээнд оролцох баг тамирчдын мэдүүлэг

Хавсралт №2

Гал унтраах техникийн олон төрөлт спортын довтолгооны шат, саадтай 100 метрийн уралдааны нэгдсэн дүн

Хавсралт № 3

4x100 метрийн буухиа уралдааны дүн

Хавсралт №4

Байлдааны тархалтын тэмцээний дүн

Хавсралт №5

Гал унтраах техникийн олон төрөлт спортын баг тамирчдын нэгдсэн амжилт, эзэлсэн байрны тэмдэглэл

Хавсралт №6

Гал унтраах техникийн олон төрөлт спортын дээд амжилт тогтоосон тэмдэглэл

Хавсралт №7

Тэмцээний ерөнхий шүүгчийн дүгнэлтийн хэлбэр

Хавсралт № 8

Гарааны шүүгчийн тэмдэглэл

Ес:Техник хэрэгслэл, замын хэмжээс /Зургаар/ :

Зураг №1

4X100 метрийн буухиа тэмцээний техник хэрэгслэл, замын хэмжээ

Зураг №2

Довтолгооны шатны тэмцээний цамхгийн стандарт, замын хэмжээ

Зураг №3

Саадтай 100 метрийн тэмцээний техник хэрэгслэл, замын хэмжээ

Зураг № 4

4x100 метрийн буухиа тэмцээний байшин, тэвшний хэмжээ

Зураг №5

Байлдааны тархалтын тэмцээний техник хэрэгслэл, замын хэмжээ

Монголын Гал унтраах техникийн олон төрөлт спортын холбооны Удирдах зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 13-ний өдрийн хурлаар батлав.



**МОНГОЛЫН ГАЛ УНТРААХ ТЕХНИКИЙН
ОЛОН ТӨРӨЛТ СПОРТЫН ТЭМЦЭЭНИЙ ДҮРЭМ
/шинэчилсэн найруулга/**

НЭГ. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

Тамирчдын тэмцээнд гаргасан амжилтын үзүүлэлт нь зөвхөн албан ёсны /олон улсын, улс, бүсийн аварга шалгаруулах/ тэмцээнүүдэд гаргасан бол хүчин төгөлдөрт тооцно. Мөн гал унтраах техникийн олон төрөлт спортын холбооноос зохион байгуулсан төлөвлөгөөнд тусгагдаагүй боловч энэхүү дүрмийн дагуу явагдсан тэмцээнүүдэд үзүүлсэн амжилтыг хүчин төгөлдөрт тооцож болно.

1.1. ТЭМЦЭЭНИЙ ТӨРӨЛ

Гал унтраах техникийн олон төрөлт тэмцээнийг насанд хүрэгчдийн, өсвөр үеийнхний гэж хоёр ангилна.

1.1.1. Насанд хүрэгчдийн тэмцээн:

- Довтолгооны шатны тэмцээн /цамхгийн 4-р давхарт гарах/
- Саадтай 100 метрийн тэмцээн
- 4x100 метрийн буухиа тэмцээн
- Байлдааны тархалтын тэмцээн

1.1.2. Өсвөрийн үеийнхний тэмцээн:

- Саадтай 80 метрийн тэмцээн
- Довтолгооны шатны тэмцээн /цамхагийн 2-р давхарт гарах/
- 5 x 80 метрийн буухиа тэмцээн

1.2. ТЭМЦЭЭНИЙГ ЗОХИОН ЯВУУЛАХ УДИРДАМЖ

1.2.1. Тэмцээнийг зохион явуулах газраас тэмцээний удирдамжийг боловсруулан баталж, дараах асуудлуудыг тусгана.

- тэмцээний зорилго
- явуулах газар, хугацаа
- тэмцээнийг удирдах, шүүгчдийг томилох
- оролцох байгууллага ба тамирчид
- тэмцээний хөтөлбөр
- тамирчдыг хүлээн авах ба байрлуулахтай холбогдсон санхүү аж ахуйн асуудал
- дүн гаргах журам (хувийн ба багийн)
- шагнал
- оролцогч байгууллагуудад тавигдах шаардлага
- мэдүүлэг ирүүлэх хугацаа, техникийн зөвлөгөөн түүний тэмдэглэл

1.2.2. Олон улсын тэмцээнийг зохион байгуулах улс, орон нь оролцох орнуудад урилгыг 6 сараас доошгүй, дотооддоо улс, бүсийн, аварга шалгаруулах тэмцээний удирдамжийг 2 сарын өмнө хүргүүлнэ.

1.2.3. Гал унтраах техникийн олон төрөлт спортын тэмцээн уралдааны бэлтгэл сургуулилт хийх, тэмцээн зохион байгуулах үед хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг бүрэн хангасан байна.

1.2.4. Тэмцээний талаар нэмэлт өөрчлөлт оруулахыг зөвхөн зохион байгуулах байгууллага гаргах эрхтэй бөгөөд тэмцээн эхлэхээс нэг сарын өмнө оролцох байгууллагад мэдэгдэнэ.

1.2.5. Тэмцээний өмнө цамхагт бэлтгэл хийх багуудын хуваарийг гаргасан байна.

1.2.6. Улс, бүсийн аварга шалгаруулах тэмцээнд оролцож байгаа багийн тамирчин өөрийн зураг, нэр бүхий мандаттай байна.

1.3. АМЖИЛТЫГ ҮНЭЛЭХ

1.3.1. Тамирчдын хувийн болон багийн амжилтыг тооцохдоо энэхүү дүрмийг баримтална.

1.3.2. Хувийн болон багийн тэмцээний дүнг гаргахдаа тамирчдын тэмцээний төрөлд гаргасан хамгийн сайн амжилтыг авч цуваагаар байр эзлүүлнэ.

1.3.3. Довтолгооны шатны болон саадтай 100 метрийн төрлийн тэмцээний багийн амжилтын дүнг гаргахдаа хамгийн сайн амжилт гаргасан 6 тамирчны цагаар авна.

1.3.4. Хэрэв хоёр багийн амжилтын нийлбэр дүн тэнцсэн тохиолдолд гараанд гарсан дарааллаар байр эзлүүлнэ.

1.3.5. Дутуу бүрэлдэхүүнтэй оролцсон багийг гүйцэд оролцсон багийн дараа байр эзлүүлнэ.

1.3.6. Хэрэв хоёр болон хэд хэдэн баг ижилхэн буюу дутуу бүрэлдэхүүнтэй оролцсон бол амжилтын дарааллаар, цаашдаа адилхан байвал сугалааны дарааллаар байр эзлүүлнэ.

1.3.7. Шигшээ гүйлт: Саадтай 100 метрийн гүйлт болон довтолгооны шатны төрөлд дээд амжилт үзүүлсэн эхний 8 тамирчныг хагас шигшээ, хагас шигшээгээс амжилтаараа тэргүүлсэн 4 тамирчныг шигшээ гүйлтэд сонгон шалгаруулж үзүүлсэн амжилтаар нь байр эзлүүлнэ.

Хагас шигшээ болон шигшээ гүйлтийн амжилт багийн дүнд орохгүй. Эхний 8 байранд шалгарсан тамирчдыг үзүүлсэн амжилтын дарааллаар сугалаа сугалуулан гүйлтийн замыг тодорхойлж дасгалыг гүйцэтгүүлнэ.

Хагас шигшээ гүйлтэд үзүүлсэн амжилтаараа эхний 4 байр эзэлсэн тамирчдыг шигшээ гүйлтэд шалгаруулж дээд амжилт үзүүлсэн дарааллаар гүйлтийн замыг сонгон шигшээ гүйлтэд уралдана. Шигшээ гүйлтэд үзүүлсэн амжилт нь уг тамирчдын хувийн амжилтын үр дүн байна. Шигшээ гүйлтэд эхний 4 байрыг шалгаруулна.

1.3.8. Буухиа уралдааны төрөлд ижил амжилттай байвал түрүүлж гараанд гарсан багийг шалгаруулна.

1.3.9. Хоёр төрөлтийн тэмцээний ялагчийг довтолгооны шат, саадтай 100 метрийн тэмцээнд үзүүлсэн дээд амжилтын нийлбэрээр шалгаруулна. Тамирчдын үзүүлсэн амжилт ижил байвал довтолгооны шатны тэмцээний төрөлд үзүүлсэн дээд амжилт нь эхний байрт шалгарах үндэслэл болно.

1.4. ТЭМЦЭЭНИЙГ ӨӨРЧЛӨХ

1.4.1. Тэмцээнийг өөрчлөх, эхлэх хугацааг хойшлуулах, эхэлсэн үед зогсоох буюу түр завсарлагаа авах шаардлага гарвал доорх тохиолдолд ерөнхий шүүгч шийдвэр гаргана.Үүнд:

- тэмцээн явуулах газар зохих ёсоор бэлтгэгдээгүй буюу явуулах боломжгүй бол,
- тэмцээнд хэрэглэгдэх хэрэгсэл төхөөрөмжүүд байхгүй буюу дүрэмд зааснаар бэлтгэгдээгүй бол,
- эмч шүүгч байхгүй зэрэг болно

1.4.2. цаг агаарын байдлаас харанхуй болох, бороо, цас орох, хүчтэй шуурга буюу тэмцээний хэвийн ажиллагаанд саад болох бусад шалтгааны үед тэмцээнийг түр хойшлуулж гүйх гүйлтийн замуудын ус, шороог арилгуулж, цэвэрлэсний дараа тэмцээнийг үргэлжлүүлнэ.

1.5. ГОМДОЛ ГАРГАХ

1.5.1. Оролцогчид ба багийн төлөөлөгчид нь тэмцээний явцын үнэн бодит байдалд үл итгэлцэл төрсөн буюу ямарваа нэгэн асуудал гарсан, мөн зарим шүүгчдийн шийдвэр нь үнэмшилтэй бус тохиолдолд багийн төлөөлөгчид ерөнхий шүүгч буюу тухайн тэмцээний ахлах шүүгч мөн түүний орлогчид багийн ахлагчаар дамжуулан гомдлоо илэрхийлэн хандаж болно.

1.5.2. Гомдлоо бичгээр тэмцээний тухайн төрлийн дүнг гаргаж дуусахаас өмнө ерөнхий шүүгчид өгөх ба гомдлын талаарх эцсийн шийдвэр нь тэмцээний дараагийн төрөл эхлэхээс өмнө гарсан байх ёстой.

1.5.3. Хэрэв энэ нь боломжгүй бол гомдол гаргасан оролцогч нь дараагийн тэмцээнд албан бус оролцогчоор оролцоно.

1.5.4. Гомдлын талаарх шийдвэр нь ерөнхий шүүгч буюу ерөнхий шүүгчийн зөвлөлийн хуралдааны тэмдэглэлд бичсэн тохиолдолд хүчин төгөлдөр болно.

1.5.5. Гомдлын талаарх шийдвэрийг нийтэд зарлаж мэдэгдэнэ.

ХОЁР. ДАСГАЛЖУУЛАГЧ, ТАМИРЧДЫН ЭРХ, ҮҮРЭГ

2.1. БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОО

Тэмцээний төрөл	тоо	амжилт
Саадтай 100 метрийн тэмцээн	8 хүн	6
Довтолгооны шатны тэмцээн	8 хүн	6
Байлдааны тархалтын тэмцээн	7 хүн	1
4x100 метрийн буухиа тэмцээн	2 баг	1

2.2. ТАМИРЧДЫГ ТЭМЦЭЭНД ОРОЛЦУУЛАХ

2.2.1. Тэмцээнд гал унтраах техникийн олон төрөлт спортын бэлтгэл хангасан тамирчдыг эмчийн зөвшөөрөлтэй оролцуулна. Тэмцээнд оролцогчийг төлөөлж байгаа байгууллага нь бэлтгэлийн үе ба тэмцээний үед гарч болох гэмтэл ослоос тамирчдыг даатгах ба аюулгүй байдлыг тамирчид өөрсдөө хариуцна. Тамирчдын тоо нь тэмцээнд орох мэдүүлэгтэй тохирч байх ёстой.

2.2.2. Тамирчдыг зөвхөн эмчийн магадалгаагаар болон ерөнхий шүүгчийн зөвлөлийн хуралдааны шийдвэрээр сольж болно.

2.2.3. Шинээр тамирчдыг оролцуулах тухай нэмэгдэл мэдүүлэг нь тухайн тохиолдолд зориулагдсан хэлбэрээр өгөгдөх ёстой. Тамирчдыг нэг төрлөөс нөгөө төрөлд оролцуулах шаардлагатай үед мэдүүлэг дээр тусгаж өгнө. Нэмэгдэл мэдүүлэг нь тухайн тэмцээний төрөл эхлэхээс нэг цагийн өмнө өгөгдсөн байх ёстой.

2.2.4. Тэмцээнд оролцож буй тамирчид нь дарга захирагчийн тэмцээнд оролцох /бэлтгэл хийх/ тухай тушаал гарсан өдрөөс тэмцээн дуусах хүртэл албан үүргээ гүйцэтгэж байгаагаар тооцох, гэмтэл бэртлийн үед даатгалын нөхөн төлбөрийг авах

2.3. ТЭМЦЭЭНД ОРОЛЦОГЧДЫН ЭРХ, ҮҮРЭГ

2.3.1. Тамирчид нь тэмцээний дүрэм тухайн төрлөөр явагдах бүх нөхцөл болзлыг урьдчилан мэдсэн байх үүрэгтэй.

2.3.2. Тэмцээнд оролцогч нь тэмцээнд бие дааж оролцох бөгөөд дасгал хийх үед бусдаас ямар нэгэн туслалцаа авах эрхгүй. Дүрэм зөрчсөн тохиолдолд тэмцээнд үзүүлсэн амжилтыг тооцохгүй.

2.3.3. Дүрэм зөрчсөн тохиолдолд тамирчинд анхааруулга өгнө. Давтан зөрчсөн тохиолдолд тамирчныг анхааруулгагүйгээр тухайн тэмцээнээс шууд хасна.

2.3.4. Тамирчин нь ерөнхий шүүгчийн зөвлөлийн шаардлагын дагуу Эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байх ёстой. Хамрагдаагүй тохиолдолд тэмцээнд оролцуулахгүй.

2.3.5. Тамирчид тэмцээний нээлт, хаалтын ажиллагаанд шүүгчийн удирдлагын дор нийтээр зохион байгуулалттай жагсах ба дүрмийн шаардлага хангасан /Аймаг, нийслэл, газар, хэлтэс, гал түймэр унтраах, аврах ангийн/ хаягтай байна.

2.3.6. Тамирчин хүндэтгэх шалтгаангүйгээр 1 ба 2 дахь оролдлогод оролцоогүй бол оролцохоос татгалзсан гэж тооцон тухайн оролдлогоос болон багийн үнэлгээнээс хасна.

2.3.7. Тухайн төрлийн тэмцээнээс чөлөөлөх эрхийг зөвхөн эмч шийдвэрлэнэ.

2.3.8. Тамирчин дасгалын талаарх асуудлаар шүүгчид хандаж болно. Бусад бүх тохиолдолд зөвхөн багийн ахлагчаар дамжуулан шүүгчид хандана.

2.3.9. Тэмцээнд оролцож байгаа тамирчин нь багийн амжилтыг ахиулах зорилгоор өөр тамирчны нэр дээр гүйлт хийхийг хатуу хориглоно. Энэ зөрчил гаргасан тамирчныг тэмцээнээс шууд хасна.

2.3.10. Улс, бүсийн аварга шалгаруулах тэмцээнд оролцож байгаа баг тамирчдыг мэдүүлэгтэй нь тулгаж үзэх /тэмцээнд оролцож байгаа тамирчин нь тухайн байгууллагад томилогдон 3-аас доошгүй сар ажилласан байх шаардлагатай/

2.4. ТАМИРЧДЫН ӨМСГӨЛ

2.4.1. Тамирчин тэмцээний бүх төрөлд дүрмээр зөвшөөрөгдсөн тусгай өмсгөл бүхий биеийн тамирын хувцастай оролцоно. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангасан галын дөлнөөс хамгаалсан дотуур подкаск бүхий өмсгөл, нүүрэвч хамгаалалт бүхий дуулга малгай, бөх бат материалаар хийгдсэн 80 мм-ээс доошгүй өргөнтэй бүстэй байна.

2.4.2. Тамирчдын хувцас, хэрэгслэл нь дараах шаардлагыг хангасан байх ёстой.

- биеийн тамирын өмсгөл нь даавуу буюу синтетик материалаар хийгдсэн гарын шуу, хөлний шилбийг халхалсан газрын түвшингээс 10 см-ээс илүүгүй байна.
- тусгай гутал буюу пүүз нь уландаа хадаастай байж болно.
- 4x100 метрийн буухиа тэмцээний 4 дүгээр замын тэвштэй галыг унтраах

тамирчин нь:

- Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангасан бээлий, нүүрний хамгаалалт бүхий дуулга малгай, подкаскастай байна.
- биеийн тамирын хувцас буюу өмсгөл малгайны өнгө, дуулга малгай нь багаараа ижил өнгөтэй байна.

2.4.3. Тамирчны хувийн дугаарыг уралдаан зохион байгуулж байгаа байгууллага хариуцна. Хэрэв тамирчдад нэг талтай дугаар өгвөл довтолгооны шатны тэмцээний үед түүнийг нуруундаа тогтоох ба бусад тохиолдолд урд талдаа тогтооно.

2.4.4. Олон улсын тэмцээнд оролцох үед тамирчдын хувцсан дээр төлөөлж буй улсынхаа эмблемтэй байж болно. Шигшээ багийн гишүүд нь биеийн тамирын хувцсанд улсынхаа далбаа, сүлдийг зүүсэн байх ёстой. Биеийн тамирын хувцас буюу малгайндаа рекламн зорилгоор ивээн тэтгэгч фирмийн таних тэмдэг зүүсэн байхыг зөвшөөрнө.

2.4.5. Хувцасны дүрмийн шаардлагыг хангаагүй тамирчныг тэмцээний гараанд гаргахгүй.

2.5. ДАСГАЛЖУУЛАГЧ БА БАГИЙН АХЛАГЧИЙН ҮҮРЭГ, ЭРХ

2.5.1. Тэмцээнд оролцогч баг болгон багийн ахлагч болон дасгалжуулагчтай байна.

2.5.2. Ахлагч нь тухайн тэмцээний дүрэм горимийг мэдэж байх ёстой ба түүнийг удирдлага болгон хэрэгжүүлэх үүрэгтэй.

2.5.3. Ахлагч нь тэмцээнийг явуулах тухай мэдээллийг ерөнхий шүүгчийн зөвлөл, тэмцээний үр дүнгийн тухай мэдээллийг нарийн бичиг шүүгчээс авах эрхтэй.

2.5.4. Багийн ахлагч нь багийг тэмцээн болох газар бэлэн байлгах, хувцаслалтыг анхаарах, албан ёсны нээлт болон хаалтын үйл ажиллагаанд оролцуулах үүргийг хүлээнэ.

2.5.5. Нэмэлт мэдүүлэг өгөх, сэлгээ хийх мэдээлэл өгөх, гомдол гаргах эрхийг зөвхөн багийн ахлагч эдэлнэ.

2.5.6. Техникийн зөвлөлгөөний хуралд багийн ахлагч заавал оролцоно. Багийнхаа нэрийн өмнөөс санал гаргах, саналаа илэрхийлэх, тэмцээний сугалаанд оролцох эрхтэй.

2.5.7. Багийн ахлагч нар тэмцээний явцад тэмцээн зохион байгуулж буй хүмүүсийн шийдвэрт оролцох, нөлөөлөхийг хориглоно.

2.5.8. Багийн ахлагч болон гишүүд нь тэмцээн бүрэн дуусаагүй буюу тухайн өдрийн тэмцээний үр дүн гараагүй байхад тэмцээнийг орхиж явахыг хориглох ба дүрмийн шаардлагыг биелүүлээгүй багийг 1 жилийн хугацаанд тэмцээнд оролцох эрхийг хасна.

2.5.9. Багийн ахлагч нь ерөнхий шүүгчийн зөвлөлийн бүх шийдвэрийг тамирчдад бүрэн хүргэж байх үүрэгтэй.

2.5.10. Багийн ахлагч байхгүй үед (хүндэтгэн үзэх шалтгаанаар) ахлагчийн бүх эрхийг дасгалжуулагч эдэлнэ.

2.5.11. Багийн дасгалжуулагч ба багийн ахлагч нь тухайн тэмцээнийг явуулах шүүгчийн зөвлөлийн гишүүн байж болохгүй.

2.5.12. Багийн амжилтыг ахиулах зорилгоор гараанд гарах ёстой тамирчны оронд өөр тамирчин гүйлгэхийг хориглох ба дүрмийн шаардлагыг зөрчсөн тохиолдолд тухайн тамирчны нийт амжилтыг багийн дүнд тооцохгүй.

ГУРАВ. ШҮҮГЧИЙН БҮРЭЛДЭХҮҮН

3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

3.1.1. Гал унтраах техникийн олон төрөлт спортын бүх төрлийн тэмцээн нь албан ёсны шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулагдана. Ерөнхий шүүгч, шүүгчийн зөвлөлийг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын даргын тушаалаар эсвэл Гал унтраах техникийн олон төрөлт спортын холбооны болон тэмцээнийг зохион байгуулах клубын тэргүүн томилж болно.

3.1.2. Шүүгчийн зөвлөлийн гишүүд нь албан ёсны таних тэмдэг зүүсэн байх ёстой. Тэмцээнийг зохион байгуулж байгаа байгууллага шүүгчийн зөвлөлийн гишүүдийг ижил өнгийн хувцсаар хангах үүрэгтэй.

3.1.3. Шүүгч нар нь ерөнхий болон ахлах шүүгчийн зөвшөөрөлгүйгээр тэмцээн зохион байгуулах журмыг зөрчих болон тэмцээний байрлалыг орхин явж болохгүй. Мөн оролцогчдод эмнэлгийн тусламжаас бусад ямар нэгэн тусламж үзүүлэхийг хориглоно.

3.1.4. Ерөнхий шүүгч нь тэмцээн явуулж буй газар, тэмцээний хөтөлбөрийн төрлөөс хамааран ерөнхий шүүгчийн зөвлөл бусад шүүгчдийг томилно.

3.1.5. Тэмцээнд цахилгаан ба механик тоног төхөөрөмж хэрэглэж байгаа үед шаардлагатай техникийн ажилтнуудыг бэлэн байлгана.

3.1.6. Асуудлыг шийдэх үед шүүгчийн зөвлөлийн санал зөрөлдсөн тохиолдолд эцсийн шийдвэр гаргах эрхийг ерөнхий шүүгч эдлэнэ.

3.1.7. Тэмцээний үеийн сахилга, ёс зүй дүрмийн шаардлагыг биелүүлээгүй тамирчинг сануулах, тэмцээнээс хасах шар, улаан картыг эрх бүхий шүүгчдийн бүрэлдэхүүн хэрэглэнэ.

3.2. ЕРӨНХИЙ ШҮҮГЧИЙН ЗӨВЛӨЛ

3.2.1. Тэмцээн зохион байгуулахын тулд ерөнхий шүүгчийн зөвлөл томилогдох ба бүрэлдэхүүнд нь ерөнхий шүүгч, орлогч, нарийн бичгийн дарга, ахлах шүүгч, шүүгч, эмч шүүгч орох ба эмч шүүгч нь тэмцээний үед гарах санал, гомдол, хэлэлцэх болон шийдвэр гаргахад оролцоно.

3.2.2. Ерөнхий шүүгчийн зөвлөлийн шүүгч нарын гаргасан шийдвэр нь эцсийн хүчин төгөлдөр шийдвэр байх ба олонхийн саналаар батлагдана. Ерөнхий шүүгчийн зөвлөл нь тэмцээний дүрэм зааварт заагдаагүй боловч учирсан тохиолдлуудын талаар шийдвэрийг гаргах эрхтэй. Гэхдээ дүрмийн заалтыг өөрчлөх эрх байхгүй.

3.2.3. Шүүгчдийн ерөнхий зөвлөлөөс дүрэм зөрчигдөж болзошгүй болон мэргэжлийн дүгнэлт гаргах шаардлагатай газруудад тус тусын үүрэгтэй шүүгчдийг хуваарилна.

3.2.4. Тэмцээний төрөл тус бүрийг шүүн явуулах ажлыг хэсгийн шүүгчийн бүрэлдэхүүнийг ерөнхий шүүгчийн зөвлөлөөс тогтоно.

3.3. ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

3.3.1. Ерөнхий шүүгч нь шүүгчийн зөвлөлийн ахлагч бөгөөд тэмцээнийг удирдан зохион байгуулагч юм.

3.3.2. Ерөнхий шүүгчийн үүрэг:

а/ тэмцээн явуулах хуваарийг өдөр, цагаар гаргуулан баталгаажуулах

б/ тэмцээнийг зохион байгуулах горимыг шүүгч, тамирчдад тайлбарлах
Үүнд:

- тэмцээний дүрмийг тайлбарлах
- албан ёсны нээлт, хаалтын үйл ажиллагааг зохион байгуулах
- гал унтраах техникийн олон төрөлт спортын төрлүүдээр явагдах тэмцээний дүрэм, журмыг тайлбарлах (гүйлтийн тоо, оролдлогыг гүйцээх нөхцөл, хувийн багаж хэрэгслийн ашиглалт гэх мэт)
- в/ шүүгчдийн ажлыг хэсэг буюу багаар хуваарилах
- г/ тэмцээн явуулах төрлүүдийн багаж хэрэгслэл, тоног төхөөрөмж нь дүрмийн дагуу бэлтгэгдсэн эсэхэд хяналт тавих
- д/ тэмцээнд оролцогчид, үзэгчид, багийн ахлагчид, радио, телевиз болон хэвлэл мэдээллийн төлөөлөгчдийг хэрэгцээтэй мэдээллээр хангах
- е/ тэмцээн зохион байгуулах газрыг тогтоох, зай хэмжилт хийх болон тэмцээний хэрэгсэл, тоноглолыг хүлээн авах актыг батлах
- ж/ тэмцээний үед гарсан гомдол буюу үл ойлголцлыг шийдэх
- з/ дээд амжилт тогтоосон амжилтыг батлах хяналт тавих
- и/ шүүгчийн зөвлөл буюу багийн ахлагч нарын хуралдааныг тэмцээн эхлэхээс өмнө, тэмцээний явц, тэмцээн дууссаны дараа зохион байгуулах
- к/ тэмцээний хэрэгцээнд хуваарилагдсан барилга, зам талбай, хэрэгслийг шалгах
- л/ тэмцээн зохион байгуулж буй клуб, байгууллагуудын тэмцээн зохион байгуулсан тайланг бичгээр гаргуулж гарын үсэг зурж холбоонд өгөх

3.3.3. Ерөнхий шүүгчийн эдлэх эрх:

- тэмцээнийг эхлэх хугацааг хойшлуулах, эхэлсэн үед зогсоох буюу түр завсарлуулах,
- тэмцээнийг зохион байгуулах график буюу журманд шаардлагатай гэж үзвэл өөрчлөлт оруулах. Гэхдээ ерөнхий шүүгч нь дүрмээр батлагдсан уралдаан зохион байгуулах нөхцөлийг өөрчлөх эрхгүй,
- насны ангилал таарахгүй, хувцаслах заавар хангаагүй ба бусад шалтгаанаар тэмцээний тухай дүрмийн шаардлага хангаагүй оролцогчдыг тэмцээнд оролцуулахгүй байх,
- Ёс зүйн болон зөрчил гаргасан, техникийн бэлэн бус байдалтай, биеийн хүчний бэлтгэл хангагдаагүй нь батлагдсан тамирчдын тэмцээнийг үргэлжлүүлэхээс татгалзах,
- тэмцээний үед шүүгчдийг өөрчлөх, солих, дүрэм зөрчсөн болон үүргээ биелүүлж чадахгүй байгаа шүүгчдийг чөлөөлөх,
- тэмцээн зохион байгуулахтай холбоотой асуудлаар эцсийн шийдвэр гаргах,
- өөрийнхөө үүргийг биелүүлж чадахгүй байгаа буюу ноцтой зөрчил гаргасан багийн ахлагч ба дасгалжуулагчдад анхааруулах, сахилгын шийтгэл оногдуулах саналаа холбооны удирдах зөвлөлд оруулах,
- гаргасан шийдвэр, үйлдэл нь буруу нь батлагдсан тохиолдолд шүүгчийн гаргасан шийдвэрийг өөрчлөх

3.4. ЕРӨНХИЙ ШҮҮГЧИЙН ОРЛОГЧ

3.4.1. Тэмцээнийг журмын дагуу шуурхай явуулах үүднээс ерөнхий шүүгчийн удирдлаган дор ажиллуулахаар орлогчийг томилж болно. Ерөнхий шүүгчгүй үед түүний үүргийг ерөнхий шүүгчийн орлогч эдэлнэ. Орлогч нарын тоо буюу тэдний үүргийн хуваарилалт нь тэмцээний цар хүрээгээр тодорхойлно.

3.4.2. Ерөнхий шүүгчийн орлогчид дараах ажлыг даалгаж болно:

- багуудын ажлын тооцоо буюу хуваарилалт;
- тэмцээний техникийн хангалт;
- тэмцээний талаархи буюу албан ёсны үйл ажиллагаануудын мэдээллийн зохион байгуулалт;

3.4.3. Ерөнхий шүүгч, шүүгчийн хэсгийн ажлыг хариуцсан орлогч дараахь үүрэгтэй:

- тэмцээнийг зохион байгуулах, тэмцээний дүрмийн дагуу явагдаж буйд хяналт тавих;
- тэмцээн зохион байгуулж байгаа байгууллагатай хамтарч шүүгчийн зөвлөлийг бүрдүүлэх;
- тэмцээн эхлэхээс өмнө шүүгчдийг зааварчлах, шүүгчдэд нэгдмэл нэг ойлголт өгөх, дүрмийн зарим хэсгийг тайлбарлах;
- шүүгчдийн хуваарилалт буюу ачааллын график гаргах
- шүүгчид, хэсгүүдийн ажлыг хянах, тэмцээний явцад шаардлагатай бол сэлгээ хийх;
- ахлах шүүгч буюу ерөнхий шүүгчийн мэдээллийн дагуу ерөнхий шүүгчийн тайланд шүүгчдийн ажил байдлын тодорхойлолт гаргах;

3.4.4. Ерөнхий шүүгчийн мэдээлэл ба албан ёсны үйл ажиллагаа хариуцсан орлогч дараахь үүрэгтэй:

- тамирчин болон үзэгчдэд мэдээллийн бүх хэрэгслийг ашиглан мэдээлэл өгөх;
- тэмцээний явц буюу үр дүнгийн талаар хэрэгцээтэй мэдээллээр хангах хүнийг томилох;
- тэмцээний нээлт, хаалт, шагнал гардуулах зэрэг албан ёсны үйл ажиллагааг удирдлагаар хангах;
- мэдээллийн хэсэг, шагналын болон радио телевиз, мэдээллийн бусад албадын хамтын ажиллагааг уялдуулан зохион байгуулах;

3.4.5. Ерөнхий шүүгчийн тэмцээний техник хангалт хариуцсан орлогч дараахь үүрэгтэй:

- материал техникийн хангалтын хэсгийг ахалж, тэмцээний явцыг хянах, хэмжилт, бэлтгэл, тэмцээнийг явуулах газрыг бэлтгэх ажлыг хариуцах;
- тамирчдын ашиглах тоног төхөөрөмжид техникийн үзлэг хийх;
- тамирчин гэмтэл авсан тохиолдолд түүний хэрэглэсэн бүх хэрэгсэлд техникийн аюулгүй байдлын акт тогтоож, шаардлагатай гэж үзвэл шалтгааныг тодруулах буюу зөвлөлдөх зорилгоор бусад мэргэжилтнийг татан оролцуулах;

3.4.6. Материал, техникийн хангалт хариуцсан орлогч дараахь үүрэгтэй:

- тамирчдыг хүлээн авах, байрлуулах, тэмцээний техник, хэрэгслийг хүлээж авах, хадгалах газар бэлтгэн шалгаж төрөлжүүлэн зохион байгуулах;
- тоног төхөөрөмж, биеийн тамирын хэрэгслүүд, шүүгчдийн хугацаа хэмжих багажууд, дохиоллын хэрэгслүүд, холбоо мэдээлэл, цахилгаан мэдээллийн хэрэгслэл, туг өргөх, чанга яригч, өсгөгч, мэдээллийн дэлгэц, шагналын тавцан зэргийг бэлтгэх;
- тэмцээн явуулах газар, техник, тоног төхөөрөмж, ерөнхий шүүгчийн зөвлөлийн ажиллах байр, техникийг бүрэн бүтэн байлгах, шүүгчийн зөвлөлийн бичиг хэрэг, барилгын план, бусад мэдээллийн материалуудыг олшруулах хэрэгслээр хангах;
- тэмцээн зохиох болон тамирчдын бэлтгэл хийх газар, байрлал, байруудыг зохион байгуулах;
- эмч буюу тэмцээнийг зохион байгуулах комиссын гишүүдийг байраар хангах, байрлуулах;
- тэмцээний үед, ёс зүйн эргүүлийг томилох ба ёс зүйн эргүүл нь бүх зааврыг ерөнхий шүүгч буюу түүний техникийн хангалт хариуцсан орлогчоос авах;

3.4.7. Тэмцээний ёс журмын эргүүл:

Тэмцээний ёс журмын эргүүл нь тэмцээн явуулах буюу бэлтгэл хийх газар, тамирчид, шүүгч нарт зориулсан байруудын эмх цэгц, дэг журам, тэмцээний үеийн хэв журам, үйлчилгээ, автомашины хөдөлгөөнийг зохицуулах, эд хөрөнгийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах ажлыг хариуцна.

3.5 ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

Тэмцээний ерөнхий нарийн бичгийн дарга нь ерөнхий шүүгчид шууд захирагдана. Ерөнхий нарийн бичгийн дарга нь мандатын комисс буюу ерөнхий шүүгчийн зөвлөлийн ажилд оролцоно.

Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэг:

- нарийн бичгийн гишүүдийн дунд үүргийг хуваарилах ажлыг зохион байгуулах;
- мэдүүлэг хүлээн авах, сугалаа сугалуулах;
- тэмцээний тэмдэглэлийг хөтлөх, багийн төлөөлөгч буюу оролцогчдод хүргэх;
- тусгай төрлөөр оролцож буй хэсгүүдийг хянан зааварлах;
- өөрсдийн ажлыг мэдээллийн төвийн удирдлагатай холбох;
- хувийн буюу багийн дүн мөн тэмцээний төрлөөр нь гарсан тэмдэглэлүүдийг нэгтгэх, зарлалын самбарт бичиж тавих, мэдээлэх;
- шүүгчдийн ерөнхий зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийг хөтлөх;
- зэргийн норматив буюу шаардлага хангасан оролцогчдыг тодруулах;
- норматив биелүүлсэн тухай тодорхойлолт олгох бөгөөд ерөнхий шүүгч, ерөнхий нарийн бичгийн дарга, ахлах шүүгч нараар гарын үсэг зуруулсан байх;
- дээд амжилт тогтоосон тухай актыг зөв бичих, түүнийг хянах, шинэ дээд амжилт гаргасан тухай актуудыг ахлах шүүгч нарын оролцоотойгоор тогтоох;
- тэмцээний үр дүнгийн материалуудыг хэвлэх, хувилах техникийн тайлан гаргах уралдааны бүх материалуудыг бэлтгэх;

3.4.9. Ерөнхий нарийн бичгийн дарга нь тэмдэглэлийн үнэн зөвийг болон оноо тоолох, оролцогч багийн байрыг тодорхойлох ажлыг хариуцна. Техникийн ажлаа явуулахын тулд тэмцээний цар хүрээнээс шалтгаалан түүний удирдлага, зааврын дагуу ажиллах туслах нарийн бичгийн даргатай байж болно.

3.6. ТӨРӨЛ ХАРИУЦСАН АХЛАХ ШҮҮГЧ

3.5.1. Төрөл хариуцсан ахлах шүүгч нь тэмцээний тухайн төрлийн хэсгийг удирдана.

3.5.2. Ахлах шүүгч нь ерөнхий шүүгчид шууд захирагдах ба түүний удирдлаган дор ажиллана.

3.5.3. Ахлах шүүгч нь дараах үүрэгтэй:

- тэмцээн эхлэхээс өмнө тухайн төрлийн тэмцээний байрыг шалгаж, тэмцээний хэрэгслийн байршил, тэмдэглэгээний зурвасыг зөв эсэхийг шалгах;
- тэмцээний хэрэгслийн төрөл, ажиллагаанд хяналт тавих;
- тэмцээний дүрэм зөрчсөн шүүгч буюу тамирчдыг хасах тухай санал оруулах;
- гарсан зөрчлийг тэмдэглэх;
- гомдлыг хүлээн авах;
- авагдсан арга хэмжээний талаар ерөнхий шүүгч буюу ерөнхий шүүгчийн орлогчдод илтгэх;
- өөрийнхөө шийдвэрийн бодит байдлыг хариуцах;

3.5.4. Ахлах шүүгч тэмцээн эхлэхээс өмнө ба дууссаны дараа тэмцээний техник хэрэгсэлд шалгалт хийнэ.

3.5.5. Ахлах шүүгч нь тэмцээний үед болсон зөрчлийн тухай ерөнхий шүүгчид мэдээлэх ба тэмцээний дүрмийн дагуу маргаантай асуудлуудаар санал оруулна.

3.7. ГАРААНЫ ШҮҮГЧ БА ТҮҮНИЙ ТУСЛАХУУД

3.6.1. Шүүгчийн хэсэг нь гарааны шүүгч болон нэг буюу хэд хэдэн туслахуудаас бүрдэнэ.

3.6.2. Гарааны үндсэн шүүгчийн гол үүрэг нь тамирчдын хэн нэг нь дохио өгөхөөс өмнө үйлдэл эхлэхийг хянана. Гарааны шүүгчийн туслах нь тамирчид дохио өгөхөөс өмнө үйлдэл хийж дүрэм зөрчсөн тохиолдолд тэднийг зогсоох буюу буцаах үүрэгтэй.

3.6.3. Гарааны үндсэн шүүгч нь дараахь үүрэгтэй:

- ахлах шүүгч болон шүүгчдийн гүйлт эхлүүлэхэд бэлэн эсэхийг шалгах;
- тамирчин нь гараан дээр зөв байрлал эзэлсэн эсэхийг нягтлах;
- эхлэх дохиог буу буюу тугаар өгнө. Дохио өгөхдөө тамирчдыг ижилхэн
- хэмжээтэй байрлалд байрлуулах;

3.6.4. Хэрэв тамирчдын аль нэг нь эхлэх дохио өгөхөөс өмнө үйлдэл хийсэн бол гарааны үндсэн шүүгч буюу түүний туслахуудын хэн ч ялгаагүй тэмцээнийг зогсоож оролцогчдод буцах дохио өгнө.

3.6.5. Гарааны шүүгч нь дохионоос түрүүлж гарсан тамирчинг улаан туг өргөж, гараанаас хасна.

3.6.6. Гарааны шүүгчийн туслах нь дараах үүрэгтэй:

- гүйлт эхлүүлэх ажлыг зохион байгуулахад туслах, тамирчдын гарааны байрлал зөв эсэхийг шалгах;
- ээлжит гүйлтийн тамирчдын ирцийг бүртгэж тэмдэглэл хөтлөх, тэмцээн эхлэхээс өмнө тамирчдын ирцийн тухай мэдээлэл өгөх;
- ямар нэгэн зөрчил гарсан тохиолдолд үндсэн гарааны шүүгчдэд мэдээлэх;
- гарааны шүүгчийн тэмцээний үед гаргасан анхааруулгыг тэмдэглэнэ;
- гарааны байранд байх ёстой хэрэгслүүдийг шалгаж тэмцээн дуусангуут гарааны шүүгч, хэсгийн гишүүд тэмдэглэлд гарын үсэг зурж тэмцээний нарийн бичигт хүлээлгэж өгөх;

3.8. ЗАМЫН ШҮҮГЧ

3.7.1 Замын шүүгч нь дүрэм зөрчсөн байдлыг тухай бүр нь барианы шүүгчид, тамирчин ба техник, хэрэгслийн бэлэн байдлын тухай гарааны шүүгчид мэдээллэж гараа, барианы шүүгчид харагдаж байхаар байрлана.

- өөрийнхөө хэсэгт тавигдсан багаж, хэрэгслийг шалгах
- тамирчдын гүйлтийг зөв гүйцэтгэж буй эсэхэд хяналт тавих
- техник, хэрэгсэл тэмцээний үед эвдэрсэн буюу техник аюулгүйн дүрэм зөрчсөн тохиолдолд шаардлагатай гэж үзвэл замын шүүгч тамирчинд гүйлтийг зогсоох дохио өгнө. Жишээ нь: "4-р замд зогс" дохиогоор тамирчин тэр дороо гүйлтийг зогсооно;

3.9. ЦАГЧИН ШҮҮГЧ

3.8.1. Цагчин шүүгч нь тамирчны гүйлтийг гүйцэтгэсэн хугацааг авч тэмдэглэнэ.

3.8.2. Цагчин шүүгчийн ажлыг ахлах цагчин шүүгч удирдана. Цагчин шүүгчид нөөц секундомертэй байна. Гүйлт эхлэхээс өмнө секундомер болон хэмжих багажаа шалгаж 0 дээр тавих ба тэмцээн эхлүүлэхэд бэлэн байгаа талаар тугаар дохио өгнө.

3.8.3. Цагчин шүүгчид нь сургалтын цамхаг дээр болон тамирчны гүйлтийн эхлэл, төгсгөл хоёрт харагдаж байхаар байрласан байна.

3.8.4. Секундомерийн үзүүлэлтийг ахлах цагчин шүүгч хянаж тэмдэглэнэ.

3.8.5. Цагчин шүүгчид нь өөрийнхөө секундомерийн үзүүлэлтийг (бусад цагчин шүүгчтэй ярилцахгүйгээр) ахлах цагчин шүүгчид мэдээлнэ. Секундомерийн үзүүлэлтийн тухай санал зөрсөн тохиолдолд эцсийн шийдвэрийг ахлах цагчин шүүгч гаргана.

3.8.6. Хугацааг тэмдэглэсний дараа цагчин шүүгч нь секундомерийн заалтыг зөвхөн ахлах цагчин шүүгчийн зөвшөөрлөөр 0 болгоно.

3.8.7. Тамирчны хугацааг 2-3 хэмжилтийн дунджаар тооцож авна. Тайлбар: Тэмдэглэлд дүнг алдаатай бичсэн тохиолдолд арилгахгүйгээр дээрээс нь ганц зурах ба хажууд нь зөв амжилтыг бичиж ахлах цагчин шүүгчийн гарын үсгээр баталгаажуулна.

3.8.8. Тэмцээнийг цахилгаан цагаар хэмжиж байгаа тохиолдолд цахилгаан цагийг амжилтаар авна. Хяналтын секундомер давхар дарж болно.

3.8.9. Тэмцээний тухайн төрлийн хөтөлбөр дуусангуут ахлах цагчин шүүгчийн баталгаат гарын үсэгтэй тэмдэглэлийг тэмцээний нарийн бичигт өгнө.

3.10. БАРИАНЫ ШҮҮГЧ

3.9.1. Барианд орохдоо гүйлтийг зөв бүрэн гүйцэтгэсэн эсэхийг тодорхойлно. Тамирчдын гүйлтийн талаар замын шүүгчдийн дүнг авч гүйлт амжилттай болсон эсэхийг тодорхойлно.

3.11. БАРИАНЫ ШҮҮГЧИЙН НАРИЙН БИЧИГ

3.10.1. Тэмцээний маргаантай асуудлаар гаргасан гомдол, саналыг гарын үсгээр баталгаажуулж ахлах цагчин шүүгчид өгнө. Тэмцээний талаарх мэдээллийг тэмдэглэнэ.

3.12. НЭВТРҮҮЛЭГЧ ШҮҮГЧ

3.12.1. Бүх тэмцээнүүдэд нэвтрүүлэгч шүүгч томилогдоно.

3.12.2. Нэвтрүүлэгч шүүгч нь гал унтраах техникийн олон төрөлт спортыг олон түмэнд сурталчилахад чиглэгдсэн байна. Тамирчид, үзэгч, дасгалжуулагч, хэвлэл мэдээллийн төлөөлөгчдийг цаг тухайд нь тэмцээний явц буюу үр дүнтэй танилцуулна.

3.12.3. Нэвтрүүлэгч шүүгч нь дараахь үүрэгтэй:

- тэмцээний багийн болон хувийн үзүүлэлтүүдийг тэмцээний хөтөлбөрийн бүх төрлөөр сайн мэдэж байх;
- тэмцээний үед нэвтрүүлэг хөтлөх, тэмцээний явцад хамгийн сайн амжилтын талаар цаг тухайд нь мэдээлэх;
- тэмцээний явц дахь ерөнхий шүүгчийн зөвлөлийн гаргасан шийдвэрийн талаар танилцуулах;
- шүүгчдийн ерөнхий зөвлөлд танилцуулсаны дагуу албан ёсны үйл ажиллагаанд зориулсан тусгай сэдвүүдийг урьдчилан бэлтгэх;

3.13. ТЭМЦЭЭНИЙ ЭМЧ ШҮҮГЧ

3.13.1. Эмч шүүгч нь шүүгчийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд орно.

3.13.2. Эмч шүүгч нь дараахь үүрэгтэй:

- мэдүүлэг өгөх үед оролцогчдын эрүүл мэндийн баримт бичгийн зөв эсэхийг шалгах ба тэмцээнд эрүүл мэндийн хувьд тэнцсэн тамирчдыг оруулахад хяналт тавих;
- тэмцээний үед тамирчдын эрүүл мэндэд хяналт тавих;
- тамирчдыг тусгай үзүүлэлтүүдээр хяналт тавих /өвдөлт, гэмтэл авсан, мөн тэмцээнийг үргэлжлүүлэх боломжгүйгээр эмчийн дүгнэлт гарсан тамирчдыг дараагийн тэмцээнээс чөлөөлөх тохиолдолд энэ тухай ерөнхий шүүгчид мэдэгдэх/;
- тэмцээнийг зохион байгуулах үеийн эмнэлэг ариун цэврийн байдлыг шалгах;
- шаардлагатай үед эмнэлэгийн тусламж үзүүлэх;
- байгууллагын журмын дагуу бусад хяналтыг зохион байгуулах;
- тэмцээний төгсгөлд ерөнхий шүүгч буюу тэмцээн зохион байгуулж буй байгууллагад эмнэлэг ариун цэвэр, тусламжийн тухай дүгнэлт, саналын хамт тайлан гаргах;

ДӨРӨВ. ТЭМЦЭЭН ЯВУУЛАХ ЖУРАМ

4.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

4.1.1. Тэмцээнийг ямар төрлөөс эхлэх, дуусах дарааллыг тэмцээний зааварт тусгах буюу газар дээр нь ерөнхий шүүгчийн зөвлөл шийдвэрлэнэ.

4.1.2. Шүүгчийн бүрэлдэхүүн гүйлтийн дарааллыг урьдчилан тогтоосон байна.

4.1.3. Саадтай 100 метрийн болон довтолгооны шатны тэмцээнүүд нь хагас шигшээ буюу шигшээ гүйлтээр аваргаа шалгаруулна. Хагас шигшээ гүйлтэнд шалгарсан 8 тамирчдыг амжилтаар жагсаан гүйх замын дарааллыг сугалаагаар тогтооно. Шигшээ гүйлтэнд шалгарсан 4 тамирчдаас дээд амжилт үзүүлсэн тамирчин замаа сонгох ба дараагийн тамирчид дарааллаараа зам дагаж хувиарлагдана.

4.1.4. Байлдааны тархалтын тэмцээний үед тамирчин техникийн алдаа гаргах эсвэл залгалтаа хийж чадаагүй бол түүнийг тухайн үедээ заавал буцааж нөхөж хийнэ. Хэрэв нөхөж хийж чадаагүй бол амжилтыг тооцохгүй. Тархалтын тэмцээнийг бүх багууд нэг төрлийн мотопомпоор ижил нөхцөлд гүйцэтгэх ёстой.

4.1.5. Тэмцээний зохион байгуулалтын буруугаас ямар нэгэн алдаа дутагдал гарах, нэгдсэн журмаар олгосон техник, зэвсэглэмж гэмтсэн, хэрэв тамирчдын буруугүй бол ерөнхий шүүгчийн зөвлөлөөс тухайн гүйлтийг давтан хийхийг зөвшөөрнө.

4.1.6. Шүүгчдэд сургалт зохион байгуулж зөвлөгөө өгсөн байна.

4.2. ГАРАА

4.2.1. Цагаан шугамуудаар тэмдэглэсэн хязгаарлалтаас тэмцээнд оролцогчид гараагаа эхлэх ёстой. Энэ тохиолдолд тэмдэглэлд зааснаар нэг удаагийн гүйлтэнд оролцогчдын тоо, цагаан шугамаар тэмдэглэсэн замын тоотой тэнцүү байна.

4.2.2. Тогтоосон хугацаанд тамирчин гарааны бэлтгэлээ хангаагүй бол гарааны шүүгч тухайн тамирчинд сануулга өгнө. Тамирчин давтан сануулга авсан тохиолдолд түүнийг гараанаас гарахыг түдгэлзүүлнэ.

4.2.3. Гарааны урьдчилсан дохиог "Гараандаа", "Анхаар" гэсэн хоёр төрлөөр өгнө. Гарааг дарцагаар буюу буугаар гаргана. Хэрэв дохио өгөхөөс өмнө заасан шугамаас түрүүлж гарвал шууд улаан туг өргөж тухайн тамирчинг гараанаас хасна.

4.3. ДУНДЫН ЗАЙ

4.3.1. Гүйлтийн үед тамирчин зөвхөн өөрийнхөө замаар гүйх ёстой. Тухайн тамирчин бусад тамирчинд саад хийж өөрийн замаас гарч замаа товчилсон тохиолдолд шүүгчид тухайн тамирчинг тэмцээнээс хасах эрхтэй. Дундын зайнд тамирчин бүх үйлдлийг бүрэн гүйцэд дүрмийн дагуу гүйцэтгэнэ.

4.3.2. Тамирчин гүйлтийн зайнд бүх үйлдлийг тэмцээний дүрэмд заасны дагуу гүйцэтгэсэн тохиолдолд тэмцээнийг дуусгасан гэж үзнэ.

ТАВ:ТЭМЦЭЭНИЙ ТӨРӨЛ, ТЕХНИК ХЭРЭГСЭЛ, ТҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА,

5.1 Довтолгооны шатны тэмцээн

5.1.1 Довтолгооны шатны тэмцээний төрөлд тавигдах шаардлага:

Довтолгооны шатны тэмцээнд багийн мэдүүлэгт бичигдсэн 8 тамирчин тус бүр 2 оролдлогыг гүйцэтгэх ба өөрийн зам, гараанд хоцролгүй оролцох үүргийг хүлээнэ. Гараанд гарах тамирчид нь дүрэмд заасан хувцас /хувийн дугаар, өмсгөл, дуулга малгай, бүс/ хэрэглэлийг бүрэн өмссөн байх ба хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгаа авч баталгаа өгсөн байх ба цамхагт ямар нэгэн бусдын дэмжлэггүй тэмцээнд оролцоно.

5.1.2. Довтолгооны шатны тэмцээний гараанд тавигдах шаардлага:

- а/Гараанд гарах тамирчин нь өөрийн гарах гарааг урьдчилан тооцоолж гарааны болон туслах шүүгчийг гараанд дуудахад бэлэн байна
- б/Гараанд дуудмагц өөрийн замын тулгуурыг богино хугацаанд тааруулна
- в/Шүүгч гараанд 2 удаа дуудаад ирээгүй бол тухайн гараанаас шууд хасна.
- г/Тамирчин нь зөвхөн өөрийн ээлжит гараанд гарах ба багийн өөр тамирчны өмнөөс зам, гараа сольж гүйхийг хатуу хориглоно.
- д/Тамирчин гарааны болон туслах шүүгчийн дохио өгсөнөөс хойш хөдөлгөөн зогсоогоогүй бол шүүгч түүнд сануулга өгч гарааг дахин эхлүүлнэ дахин хэрэгжүүлээгүй бол тухайн гүйлтээс шууд хасна.
- е/Тамирчин гарааны шугаман дээр гишгэлгүйгээр байраа эзэлнэ. /Довтолгооны шатыг авч гүйхэд шатаа өөртөө тохиромжтой байдлаар барьж болно/

ё/Гараанд дуудсан үед бие халаалт хийх зорилгоор цамхагт довтолгооны шаттай тавилт хийх, шат авч гүйхыг хориглоно.

ж/Шүүгчийн “Анхаар” дохиогоор хөдөлгөөнөө зогсоох ба шатыг газраас хөндийрүүлэхийг хориглоно.

з/Довтолгооны шатыг цонхноос цонх руу шилжүүлэхдээ босоо байдлаас шилжүүлэхийг хориглоно

и/Шүүгчийн дохиогоор гараанаас гарч замын гүйлт хийх гүйх үед бусад тамирчинд саад хийхгүй байх ёстой.

й/Тамирчин цамхагт тавилт /зоолт/ хийх, давхар дунд гүйж байх үед хажуу замын тамирчин илт саад учруулсан бол тухайн тамирчинг тухайн төрлөөс хасч хохирсон тамирчинг дахин гүйлгэнэ.

к/Барианд тамирчны хоёр хөл шаланд бууснаар амжилтыг тооцох ба хөл цуварч орсон бол сүүлийн хөл шалан дээр бууснаар амжилтыг тооцно.

5.1.3. Довтолгооны шатны тэмцээний цамхагт тавигдах шаардлага:

5.3.1. Гүйлтийн талбайн урт нь 50 метрээс дээш, өргөн нь хэрэв 4 замтай бол 10 метр, 2 замтай бол 5 метрээс багагүй байна.

5.3.2. Цамхаг хүртэл гүйх талбай нь тэгшхэн, тамирчдад гэмтэл учруулж болох ир, үзүүртэй зүйл, чулуугүй байвал зохино.

5.3.3. Цамхаг нь 4 давхар байна. Цамхагийн талбай руу харсан нүүрэн талд дараахь зүйлүүдийг байрлуулна:

а/ нэг давхраас бусад давхарт 1.1 метр өргөн, 1.87 метр өндөр хэмжээтэй цонхтой байна.

б/ цонхноос цамхагийн хананы ирмэг хүртэл 65 см, хоёр цонхны хооронд 60 см-ээс доошгүй зайтай байна.

в/ цонхны тавцангийн өргөн нь 37-39 см байна.

г/ цонхны тавцангийн дээд ирмэгээс шал хүртэл 80 см байхаар тооцно.

д/ газраас хоёрдугаар давхрын цонхны тавцангийн ирмэг хүртэл 4.25 метр, давхруудын цонхны тавцангийн хоорондох зай нь 3.3 метр байна.

е/ давхруудын цонхны тавцан нүүрэн талдаа гадагш 5-6 см илүү цухуйсан байна. Давхар бүрийн цонхны тавцангийн цухуйсан хэсэгт шатыг доргилтоос хамгаалсан зөөлөвчийг үндсэн хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр хадна.

ё/ цамхагийн нүүрэн талд ямар нэгэн гадагш гарсан зүйл байж болохгүй. Хоёрдугаар давхрын цонхны тавцангаас доош 3,20 м зайд 6х6 см огтлол бүхий брусс модыг үргэлжид нь хадна. Давхар дундын цонхны хөндийрүүлэгч брусс ч мөн адил байна.

ж/ цамхагийн давхар бүрийн цонхны цаана 1.5 метрийн өргөнтэй талбай байх бөгөөд тэр нь байнгын шаттай шууд холбогдсон байна. Байнгын шат нь цамхагийн дотор буюу цонхны эсрэг талд байрласан байна.

з/ сургуулийн цамхаг нь найдвартай бат бөх материалаар хийгдэж төхөөрөмжлөгдсөн байна.

и/ цамхагийн өмнө талд Гал түймэр унтраах дүрэмд заасны дагуу цамхагийн өргөнөөс 1 метр илүү урт, 4 метр өргөн, 1 метр гүн нүхийг ухаж хамгаалалтын зөөлөвчийг хийж аюулгүй байдлыг хангасан байна.

й/ Цамхгаас гарааны шугам хүртэлх зай 32,25 м байна.

к/Цамхагийн урд талд хамгаалалтын торыг татсан байна.Энэ тор нь цамхгийн урттай ижил хэмжээтэй, 2 м-ээс багагүй өргөнтэй, газрын түвшинээс 5,15 м өндөрт цамхгийн нүүрэн талаас 75 см зайтай бат бөх олсон материалаар сүлжиж хийсэн байна.

5.4.1 Довтолгооны шатны тэмцээний хэрэгсэлд тавигдах шаардлага:

а/Довтолгооны шатны арааны урт нь 40 см-ээс богиногүй, арааны холбоос хэсэг 6 см-ээс багагүй, араа бэхэлгээнд байрлах хэсэг 90

градус, арааны шүд 8-аас доошгүй, жин 8.5 кг-аас багагүй, гуя хоорондын хэмжээ 30 см-ээс багагүй өргөнтэй арааны шүд 1,5-2,0 см өндөртэй ямар нэг гэмтэлгүй бүрэн бүтэн байна.

б/Шатны араа, хөндлийн бэхэлгээ заавал хийгдсэн байна.

в/Шатыг хөнгөлөх зорилгоор хийц материалын, бат бөх чанарыг алдагдуулахыг хориглоно

5.2 4x100 метрийн буухиа тэмцээн

5.2.1 Буухиа уралдааны төрөл нь 400 метрийн урттай, зууван цагираг хэлбэртэй 100 метр бүхий дөрвөн хэсэг гүйлтийн замаас бүрдэл болох ба замын өргөн 2,5 метр, хязгаарлах шугамны өргөн 5 см, гүйлтийн замыг зүүн гар талаас 1, 2 дугаар зам гэж дугаарлаж дасгал гүйцэтгэх аргачлалаар зохион байгуулна.

5.2.2. Гүйлтийн замын урт, хэрэглэлийн хэмжээг тавихдаа замын зүүн гар талын хязгаарлах шугамнаас 30 см зайтай, хоёрдугаар замыг 20 см зайтай хэмжинэ.

5.2.3. Зам тус бүр дээр дараах багаж хэрэглэлийг байрлуулна.

а/ Нэгийн замд: Гараанаас 30 метрийн зайд байшин байрлана. Байшингийн нийт урт нь 5000 мм, өргөн 2360 мм, дээврийн оройн өндөр 2150 мм, оройн үзүүрээс хоёр налуу тавцан руу тус тусад нь 300 мм, өргөн 60 мм ухаадас гаргаж өгнө. Буух тавцангийн урт 1000 мм, өндөр 1700 мм, налуу тавцангийн урт 4000 мм, өргөн 1500 мм байна. Дээврийн налуу тавцангийн доод ирмэгээс дээш 200 мм зайд өргөн нь 100 мм, зузаан нь 60 мм шугаман модтой байна.

Энэ замд ашиглах шат нь эвхдэг болон эвхдэггүй, модон болон төмөр хийцтэй шат нь 3100 мм-ийн урттай, 8 хөндөлтэй, 30 см-ийн өргөнтэй 8,5 кг-аас багагүй жинтэй байна.

б/ Хоёрын замд: Нэгдүгээр замын гараанаас 90 метрт хушуу дамжуулах 50 мм-ийн өргөнтэй тасархай шугаман тэмдэглэгээг татах ба хоёрдугаар замын эхлэлээс 10 метрт хушуу дамжуулж дуусах тасархай шугаман тэмдэглэгээг тус тус татна. Хоёрдугаар замын эхлэлээс 50 метрт 2x2 метрийн харьцаатай, зузаан нь 40-50 мм, хоёр талдаа 50x80 мм-ийн резинэн хавтан хадсан самбар байрлуулна.

в/ Гурвын замд: Замын эхлэлээс 10 метрт хушуу дамжуулж дуусах тасархай шугаман тэмдэглэгээ, 15 метрт хоолой байрлуулах 50 мм өргөнтэй шугаман тэмдэглэгээ, 25 метрт гүүрний налуу хэсгийн үзүүр байрлах бол 55 метрт салаа билчир, 80 метрт хоолойноос хушууг салгах хязгаарлах шугам, 90 метрт хушуу дамжуулах тасархай шугам байрлана.

г/ Дөрвийн замд: Замын эхлэлээс 10 метрт хушуу дамжуулж дуусах тасархай шугамыг татаж 20 метрт гал унтраагуурыг байрлуулна. Замын 50 дахь метрт урт нь 1500 мм, өргөн 1000 мм, өндөр 200 мм гал асаах тэвшний голыг тааруулан замын баруун хэсэгт байрлуулна. Тэвш тавьсан тэмдэглэгээнээс 50 метрт барианы шугаман тэмдэглэгээг татна.

5.2.4. Зам тус бүр дээр дараах дасгалыг гүйцэтгэнэ. Тухайн төрөлд оролцож байгаа тамирчид шаардлага хангасан хамгаалалтын нэг ижил өнгийн малгай, өргөн нь 80 см-ээс багагүй аврах бүс, гарын бугуй, хөлийн шагай дарсан ижил төрлийн хувцастай байна.

а/ Нэгдүгээр замын дасгал гүйцэтгэл: Тамирчид нам гараанаас 500 гр жинтэй, 250 мм урттай хушуутай, 8,5 кг-аас багагүй 8 хөндөл бүхий эвхдэг шаттай гараанаас гарна. Тамирчинг гараанд гарахаас өмнө дөрөвдүгээр замын шүүгч ус, түлш хоёрыг тэвшинд хийсэн байна. Байшин дээгүүр гүйх тамирчин нь байшингийн баруун, зүүн аль ч налуугаар дасгалыг гүйцэтгэж болох ба цаашид сул зайд гүйлт хийж хоёрдугаар замын тамирчинд хушууг

дамжуулна. Тамирчин байшин дээгүүр гүйх үйлдлийг амжилттай хийж гүйцэтгэн гүйлтийн зам дээр буух үед дөрөвдүгээр замын шүүгч бензинийг шатах шингэн бүхий тэвшинд хийнэ. Хоёрдугаар замын тамирчин тасархай шугамны наанаас гүйлтийн хөдөлгөөнийг эхэлж болох боловч зөвхөн хязгаарлах тасархай шугам давсаны дараа хушууг авах ёстой. Жич: Эвхдэг шат зоох газрын гадаргуугын хэсгийг ухах зэргээр өөрчлөхийг хориглох ба зөөлөвч хэрэглэхийг зөвшөөрнө.

б/Хоёрдугаар замын дасгал гүйцэтгэл. Энэ замд дасгал гүйцэтгэх тамирчин хушууг ямар ч байдлаар авч явж болох бөгөөд самбарыг даван гуравдугаар замын тамирчинд хушууг дамжуулна.

Хоёрдугаар замын тамирчин самбарт дасгал гүйцэтгэхээр тавцанд хөл хүрэхэд дөрөвдүгээр замын шүүгч урьдчилан бэлтгэсэн тэвштэй шатах шингэнийг асаана.

Гуравдугаар замын тамирчин тасархай шугамны наанаас гүйлтийн хөдөлгөөнийг эхэлж болох боловч зөвхөн хязгаарлах тасархай шугам давсаны дараа хушууг авах ёстой.

в/Гуравдугаар замын дасгал гүйцэтгэл. Тамирчин хушууг ямарч байдлаар авч явж болно. Тус бүр нь 2,5 кг жинтэй, 20 метрийн урттай, гурван хумс бүхий тотготой хос хоолойг өөрт тохиромжтой аргаар авч гүүрэн дээгүүр гүйх дасгалыг гүйцэтгэн буухдаа хоолойг дэлгэн дундын холболтыг хийнэ.

Хоолойн нэг тотгыг гүйлтийн замын тэгш гадаргуйгаас 6 см-ийн өндөрт байрлах салаа билчирийн тотгонд залгаж, нөгөө үзүүрийг хушуунд залган хязгаарлах шугамыг өнгөрмөгц хушуугаа салгаж дөрөвдүгээр замын тамирчинд хушууг дамжуулна.

Дөрөвдүгээр замын тамирчин тасархай шугамны наанаас гүйлтийн хөдөлгөөнийг эхэлж болох боловч зөвхөн хязгаарлах тасархай шугам давсаны дараа хушууг авах ёстой.

д/Дөрөвдүгээр замын дасгал гүйцэтгэл. Замын эхлэлээс 20 метрт байрлах 5 ± 1 кг жинтэй гал унтраагуурыг гүйлтэн дундаа авч 50 метрт байрлах тэвшинд /30 литр ус, 2 литр түлш, 0,25 литр бензиний орцтой/ асч байгаа шатах шингэний галыг бүрэн унтрааж цааш 50 метрт чөлөөт гүйлт хийн барианд орсоноор багийн амжилтыг авна.

Энэ үед гал унтраагуур түгжээгүй байх бөгөөд ямар ч аргаар авч явж болно. Хэрэв унтрааж чадахгүй буюу ажиллахгүй тохиолдолд нөөц гал унтраагуурыг ашиглаж болно.

Гал унтраах техникийн олон төрөлт спортын холбоо нь нэг маркийн ижил даралттай гал унтраагуураар тэмцээнд оролцуулна. Техникийн ажилтнууд нэг төрлийн ижил даралттай гал унтраагуур, тэвшинд гал асаах түлш, бензин, усыг дүрмийн дагуу ижил хэмжээтэйгээр савлан дугаарлаж тэмцээнд оролцох гарааны дараалал, сугалаагаар олгоно.

5.2.5. Шүүгчийн дохио дуугарсанаас хойш дараах тохиолдол учирсан бол амжилтыг тооцохгүй:

- а/ Тамирчин гараанаас гарахдаа аврах бүс, хамгаалалтын малгай, хувийн дугааргүй гарсан
- б/ Байшинд дасгал гүйцэтгэсэн шат 8,5 кг бага байсан
- в/ Байшинд дасгал гүйцэтгэж байгаа тамирчин гүйлтын зам дээр буугаагүй байхад шат унасан / үйлдлийг давтан гүйцэтгэж болно/
- г/ Хушууг дамжуулах хязгаарлалтын шугаман дээр гишгэсэн буюу хэтэрсэн
- д/ Самбар давах дасгал гүйцэтгээгүй
- е/ Гүүрэн дээр дасгал гүйцэтгэхдээ хязгаарлагч шугамны дотор буусан /дасгалыг дахин гүйцэтгэж болно/
- ё/ Холбох тотго залгагдаагүй, хоолой тасарсан тохиолдолд /тухайн үед залгагдаад гүйлтэн дунд салсан, тасарсан бол залгагдаагүйд тооцно/

ж/ Салаа билчирт гурван хумстай тотгоны хумс дутуу орсон буюу хумсны өргөнтэй тэнцэх хэмжээтэй зайтай бол
з/ Хушуу салган дамжуулах үед хоолойн тотго хязгаарлах шугаман дээр буюу наана нь унасан
и/ Тэвшин дэх шатах шингэний галыг бүрэн унтраагаагүй бол
й/ Тамирчин барианд орохдоо хушуугүй, дуулга малгайгүй, хөдөлмөр хамгааллын хэрэгслийг гээгдүүлсэн бол
[/ Тамирчин хажуугийн замын хязгаарлах шугам руу орсон тохиолдолд тус тус амжилтыг тооцохгүй

5.3 Саадтай 100 метрийн тэмцээн

5.3.1 Саадтай 100 метрийн гүйлтийн тэмцээний төрөлд тавигдах шаардлага:

Саадтай 100 метрийн гүйлтийн багийн мэдүүлэгт бичигдсэн 8 тамирчин 2 оролдлогыг гүйцэтгэх ба өөрийн зам, гараанд хоцролгүй оролцох үүргийг хүлээнэ. Гараанд гарах тамирчид нь дүрэмд заасан хувцас /хувийн дугаар, өмсгөл, дуулга малгай, бүс/ хэрэглэлийг бүрэн өмссөн байх ба хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгаа авч баталгаа өгсөн байна.

5.3.2 Саадтай 100 метрийн гүйлтийн тэмцээний гараанд тавигдах шаардлага:

а/Гараанд гарах тамирчин нь өөрийн гарах гарааг урьдчилан тооцоолж гарааны болон туслах шүүгчийг гараанд дуудахад бэлэн байна

б/Гараанд дуудмагц өөрийн замын тулгуурыг богино хугацаанд тааруулна в/Шүүгч гараанд 2 удаа дуудаад ирээгүй бол тухайн гараанаас шууд хасна.
г/Тамирчин нь зөвхөн өөрийн ээлжит гараанд гарах ба багийн өөр тамирчны өмнөөс зам, гараа сольж гүйхийг хатуу хориглоно.

д/Тамирчин гарааны болон туслах шүүгчийн дохио өгсөнөөс хойш хөдөлгөөн зогсоогоогүй бол шүүгч түүнд сануулга өгч гарааг дахин эхлүүлнэ дахин хэрэгжүүлээгүй бол тухайн гүйлтээс шууд хасна.

е/Тамирчин гарааны шугаман дээр гишгэлгүйгээр байраа эзэлнэ /хушуу нь 40-см-ээс багагүй оосор, бүсэнд өлгөх тогтоогчтой байна./

ё/Гараанд дуудсан үед бие халаалт хийх зорилгоор самбар, гүүрт дасгал гүйцэтгэхийг хориглоно.

ж/Шүүгчийн “Анхаар” дохиогоор хөдөлгөөнөө зогсоох ба өвдгийг газраас хөндийрүүлэхийг хориглоно.

Тамирчин нь шүүгчийн дохиогоор гараанаас гарч самбарыг даван, хос хоолойг авч гүүрэн дээгүүр гараад, хоолойг хооронд нь холбон салаа билчирт хоолойн нэг тотгыг, нөгөөг хушуунд залгаж барианд орно. Барианд орохоос өмнө хоолойг хушуунд залгасан байх ёстой.

5.3.3 Саадтай 100 метрийн тэмцээний төрөлд зөвхөн 3 хумстай тотгоор оролцохыг зөвшөөрнө.

5.3.4 Талбайг ахлах шүүгч өөрийн биеэр хэмжиж шалгана.

5.3.5 Хоолойг газарт тогтоох зорилгоор ямар нэг тогтогч, суурь хийхийг хориглоно. Мөн хоолойн голд өөр төрлийн нэмэлт зүйлээр /сангийн хоолой г.м/ өндөрлөхийг хориглоно. Харин хоолойд өөрт нь тогтоогч хийж болно.

5.3.6 Шүүгчийн дохио дуугарсанаас хойш дараах тохиолдол учирсан бол амжилтыг тооцохгүй:

а/ самбарын тулгуурын хэсгийг дөрөөлж давсан.

б/ гүүрэн дээгүүр гүйж байхдаа хязгаарлагч шугамны дотор буувал (хэрэв хязгаарлагч шугамны дотор буувал буцаж дахин гүүрэн дээгүүр гүйж болно.)

в/ тотго залгагдаагүй бол (залгагдаад чирэгдэж салсаныг залгагдаагүйд тооцно)

д/ хушууг барианд орсон хойно залгавал.

е/ дуулга малгай барианд ороогүй байхад унавал (унасан малгайг авч өмсөөд орж болно)

ё/ хоолой тасарвал.

ж/ Ямар нэгэн байдлаар хушууг барьж барианд орвол. Хушуу нь оосортой байхаас гадна барианд орохдоо заавал хушууг оосроор чирж орно.

5.3.7 Саадтай 100 метрийн тэмцээний техник хэрэгсэлд тавигдах шаардлага:

а/ Замын урт 115 метрээс доошгүй (өсвөр үеийнхэн 90 метр), замын өргөн 2,5 метр байна. Замын эхлэл, төгсгөлийн хэмжээнээс гадагш гараа, барианд зориулж 5 метрээс доошгүй зайг гаргана. Тэмцээнийг 2 ба түүнээс дээш замаар явуулбал зам бүрийн өргөн 2 метрээс доошгүй байна. Замын хөрс хатуу хучилттай, тэгш шулуун, саадгүй байна.

б/ Замыг тусгаарласан шугамыг цагаан өнгөөр зам дагуу, гараа, бариа болон самбар, хоолой, салаа билчир тавих хэсэгт хөндлөн шугам татна. Цагаан шугамны өргөн 5 см байна.

5.3.9 Тэмцээнд шаардагдах багаж хэрэгсэл, байрлал:

а/ гарааны шугамнаас 23 метр (өсвөр үеийнхэнд 15 метр) зайд 2 метр өргөн, 2 метрийн өндөртэй, 4 см зузаан банзаар хийгдсэн самбарыг байрлуулна.(өсвөр үеийнх 1.5 метр өргөн, 1.7 метр өндөр)

б/ гараанаас 28 метр (өсвөр үеийнхэнд 20 метр) зайд эвхээтэй хоёр хоолойг тамирчид авч гүйхэд хялбар байдлаар тавина. Хоолой нь 51 мм-н, урт нь тус бүр 20 метрээс багагүй (өсвөр үеийнхэнд хоолой нь 15 метрээс багагүй), хоолойн хүнд 5 кг-аас доошгүй (өсвөр үеийнхэнд 3 кг-аас доошгүй) байна;

в/ гараанаас 38 метр (өсвөр үеийнхэнд 30 метр) зайд гүүрний урд гишгүүрийн үзүүрийг байрлуулна. Гүүрийн дээд тал нь 18 см-ийн өргөн гүйхэд хотолзохгүйгээр хийгдэнэ. Гүүрний урт 8 метр (өсвөр үеийнхэнд 6 метр), газраас дээш ирмэг хүртэл 1.2 метр (өсвөр үеийнхэнд 0.8 метр) өндөртэй байхын дээр, дор нь тулгуурууд хийнэ. Гүүрийн хоёр талд тус бүр 2 метр (өсвөр үеийнхэнд 1.5 метр) урттай 25 см-ийн өргөнтэй налуу гарч, буух гишгүүр бэхлэгдэнэ. Налуу дээр 5 см өргөн 3 см өндөртэй хөндөл модуудыг дээд талаас нь эхлэн 35 см зайтайгаар хадна;

г/ гараанаас 75 метр (өсвөр үеийнхэнд 58 метр)-зайд салаа билчирийг байрлуулна. Салаа билчир нь дүрмийн шаардлагад нийцсэн хөлтэй байж болох ба салаа бичирийн хоёр талын 51 мм-н 2 тотго нь крантгүй байж болно. Харин дунд талын тотго заавал кранттай байна. Салаа билчирийн тотго нь газрын түвшингөөс 6 см-ээс илүүгүй өндөрт байрлаж ямар нэг засваргүй, дээшээ, доошоо хазайлтгүй 90 градусын өнцөгтэй байна.

д/ Хушууны урт 32 см, жин нь 40 гр-аас багагүй, оосорны урт нь 40 см-ээс уртгүй байна.

5.4 Байлдааны тархалтын тэмцээн

5.4.1 Байлдааны тархалтын тэмцээний баг тамирчдад тавигдах шаардлага:

Байлдааны тархалтын тэмцээнд багийн мэдүүлэгт бичигдсэн тамирчдаас зөвхөн 7 тамирчин нь оролцоно. Баг тамирчид тэмцээний дүрэм, шүүгчийн шаардлагыг бүрэн ойлгосон, тэмцээнд хэрэглэгдэх багаж техник, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн, найдвартай ажиллагаа, шаардагдах хэмжээг бүрэн хангасан байна. Тэмцээнд хэрэглэх багаж тоног төхөөрөмжид хугацаа хожих зорилгоор ямар нэгэн засвар хийгдээгүй байна.

5.4.2 Байлдааны тархалтын тэмцээний бэлтгэл гараанд тавигдах шаардлага:

Гараанд гарах багийн ахлагч нар мэргэ онох цоргоны хэвийн найдвартай ажиллагаа, бэлэн байдалтай техник хэрэгслийн болон, цагчин шүүгчийн хамт танилцсаны дараа гараанд гарна. Тамирчид өөрийн гүйцэтгэх даалгавар, багаж хэрэгслийг тавцанд дүрмийн дагуу байрлуулж тавцангийн зүүн болон урд хэсэгт 10 метрийн зайд урьдчилан тэмдэглэсэн гарааны шугамын аль нэгийг сонгон бүгд нэг талаас гарна. Гараанд гарахын өмнө багийн ахлагч гарааны шүүгчид багаж хэрэгслийн бэлэн байдлыг биечлэн шалгуулах ба дараах шаардлагыг хангасан байна.Үүнд:

а/ Усны онгоц усаар дүүрэн байна

б/ мотопомны ус, бензиныг цэнэглэсэн байна

в/ мотопомны гарах төв шугамын хаалт нээлттэй байж болно.

г/ бүх хоолой, хушуу салаа билчир хоорондоо залгагдаагүй тус тусдаа байна

д/ Хоолой, төхөөргийн холбоосуудын хумсны хоорондуур нимгэн хуудас /1мм-ийн/ орж байхаар зайтай бэлтгэж байрлуулна.

е/ Сорох хоолой, сорох тор залгагдаагүй байх ба сорох тор тавцангаас илүү гарах ёсгүй.

ё/ Хоолой, хэрэгслүүд тавцангаас илүү гараагүй байна. /Зөвхөн сорох хоолойн хэсгийг илүү гаргаж болох ба газар хүргэж болохгүй/

ж/ Хоолойн нөхөөс, түлхүүрийг бэлтгэсэн байна

з/ гарааны бэлтгэл ажил 5 минутаас ихгүй байна.

з/ мотопомпны найдвартай ажиллагааг шалгаж бэлтгэсэн байна.

Байлдааны тархалтын тэмцээнд бэлтгэл гарааны нөөц тавцанг бэлтгэсэн байна. Төв шугаманд зөвхөн 3 тотготой салаа билчир хэрэглэх ба 2 захын тотгоны крант хаалттай, харин төв крант хагас нээлттэй байхыг зөвшөөрнө.

Гараанд 2 мотопомпыг сугалаагаар сонгон байрлуулах ба нөөцөнд мөн адил 2 мотопомпыг сонгон бэлтгэнэ.

5.4.3 Гараанд гарсан тамирчдад тавигдах шаардлага:

Баг тамирчид гарааны шүүгчийн / анхааруулах ГАРААНДАА, МАРШ/ дохиогоор гараанаас нэг зэрэг гарна. Үүнд:

а/ хушуучид мэргэ буудахдаа суугаа, босоо аль ч хэлбэрийг сонгон байрлаж болно.

б/ хушуучин мэргэ онохдоо хязгаарлалтын шугам давахыг хориглоно

в/ өөрсдийн байрлалаас хөдлөлгүйгээр бие биендээ тусалж болно.

г/ зөвхөн сүүлийн цоргоны гэрэл ассан тохиолдолд цагийг тэмдэглэж амжилтыг тооцно.

д/ хоолой цоорвол нөхөөс ашиглаж болно.

е/ хоолой болон мотопомпны тросс тасарвал техникийн саатал гэж үзэхгүй.

ё/хушуунд хоолойгоор дамжин чулуу бусад биет зүйл орж бөглөрвөл техникийн саатал гэж үзэхгүй.

з/хэрэв хоолой, салаа билчирт залгагдаагүй үед ус ирвэл тамирчид нийлүүлэн барьж ус гүйлгэхийг зөвшөөрнө.

ж/ сорох шүүрийг усан дотор залгаж болохгүй.

и/ байлдааны тархалтыг нэг адилхан хүчин чадалтай мотопомпоор явуулна.

й/ байлдааны тархалтын төрөлд баг зам сольж 2 удаа оролцоно.

к/ талбайг ахлах шүүгч өөрийн биеэр хэмжиж шалгана.

5.4.4 Шүүгчийн дохио дүүгарсанаас хойш дараах тохиолдол учирсан бол амжилтыг тооцохгүй:

а/ мэргэ оносны дараа сорох шүүр залгагдаагүй буюу салсан байвал

б/ мэргэ оноход усан сангийн ус дуусч цаашид тэмцээн үргэлжлэх боломжгүй болсон бол

в/ мотопомпыг ажиллуулж чадаагүйгээс тэмцээн үргэлжлээгүй бол

г/ Ус болон хоолойд ямар нэг химийн гаралтай бодис хийгдсэн байвал

д/ Мэргэ онох тамирчид нь хязгаарлах шугамыг давж биеийн аль нэг хэсэг болон хушууг хэтрүүлсэн бол

е/ хушуучин мэргэ онохдоо хушуу, хоолойн хэсгийг газар тулбал

ё/ сорох шүүрийг усыг соруулахаас өмнө холбоогүй бол

ё/ гарааны бэлтгэл ажил 5 минутаас +1 мин илүү хугацаа хэтэрсэн бол

ж/хувцаслалтын шаардлагыг зөрчин дасгалыг гүйцэтгэсэн тохиолдолд

/ багийн гишүүдийн өмсгөл, дуулга малгай жигд байхыг шаардана/

з/ гэрэл ассан ч цоргон дахь усны хэмжээ 10 л-т хүрэхгүй байвал техникийн саатал гэж үзэн тухайн багийг дахин гүйлгэнэ.

5.4.5 Байлдааны тархалтын төрөлд мотопомпноос гадна дараахь хэрэглэлийг ашиглана. Үүнд

Байлдааны тархалтын тэмцээний техник хэрэгсэл, тоо ширхэг.

№	Нэр төрөл	Тоо ширхэг	диаметр	урт
1	Сорох хоолой	2ш	100мм	2,5 м

2	Сорох шүүр	1ш	100мм	-
3	Төв шугамын хоолой	3ш	66мм	19м-ээс багагүй
4	Ажлын шугамын хоолой	4ш	51мм	19м-ээс багагүй
5	Салаа билчир	1ш	50x50x66	3 тотготой хаалттай
6	Хушуу	2ш	Залгалтын d/50 мм Торгон үзүүрийн d/13 мм-ийн голчтой, хушууны урт 40 см-ээс ихгүй байна.	
7	Хоолойн түлхүүр	2ш	50, 66	-
8	Хоолойн нөхөөс	1ш	-	-
9	Хэрэгслэл байрлуулах тавцан	1ш	2 м x 2 м	
10	Усны ган сав	1ш	1000л	H=800мм L=1200мм D=1100мм
11	Мэргэ онох цорго	2ш	10 л-ийн багтаамжтай	

5.4.6 Байлдааны тархалтын тэмцээний төрлийн зай, хэмжээ:

Байлдааны тархалтын тэмцээний төрөлд хэрэглэгдэх техник хэрэгслүүд нь аюулгүй ажиллагааны дүрэм журамд нийцсэн, гал унтраах үйл ажиллагаанд ашиглагддаг багаж, тоног төхөөрөмжөөс бүрдсэн, стандартад нийцсэн байна.

8.1.7 Байлдааны тархалтын тэмцээний төрөлд хэрэглэгдэх техник хэрэгслүүдийг дараах зай хэмжээнд байрлуулна. Үүнд:

а/Тавцангийн баруун гар талд тавцангаас 4 метрийн зайд усны сав байрлуулна.

б/Гарааны шугамыг тавцангийн голоос 10 м зайтай 2 хэсэгт тэмдэглэж дарцаг хатгасан байна.

в/Тархалтын нийт замын урт 100 м байна

г/Гарааны шугамаас тавцанг голлон 100 метрт хоорондоо 5 метрийн зайтай онох мэргийг байрлуулна. /цоргоны хоорондын хэмжээг онох мэргэн төв цэгээс хэмжсэн байна/

д/Хушуучдын мэргэ онох зай 5 м байх ба дарцаг хатгаж тэмдэгжүүлсэн байна.

е/Цоргоны нийт өндөр 1750 мм, онох мэргэний төв цэг нь 1500 мм байхаар хийгдсэн байна.

ё/Цоргоны /шилэн хийцний/ өргөн нь 500 мм, өндөр 1000 мм, онох мэргэний, онох мэргэний төв цэгийг цоргоны дээд ирмэгээс 250 мм-д зайд 50 мм-ийн диаметртай байхаар тооцоолно. Онох мэргэний хүрээний тойргийн /тэмдэглэгээ/ диаметр 300 мм байна. Суурьны өндрийг газрын түвшнээс 1700 мм байхаар, шилэн хийцнийг 1750 мм-д байхаар тооцно.

ж/Цорго нь олон улсын стандартад нийцсэн усны урсгал харагдахуйц бат бөх материалаар хийгдсэн байх ба 10 л ус дүүрмэгц гэрэл асах төхөөрөмжөөр тоноглогдсон, дүүрсэн усыг юүлэх хаалт бүхий цорготой байна.

з/Цоргоны суурийг аль болох усны цохиолтод найдвартай байхаар ба бөх, тогтвортой байхаар хийсэн байна.

и/Өрсөлдөгч багийн цоргоны байрлах хэмжээ хоорондоо 10 м зайнд мөн ижил шаардлагыг хангасан байна.

5.5 Хоёр төрөлтийн тэмцээн

5.5.1. Энэ тэмцээнд дараах төрөл хамаарна. Үүнд:

- саадтай 100 метрийн тэмцээн;
- довтолгооны шатны тэмцээн

5.5.2. Хоёр төрөлтийн дүнг саадтай 100 метр, довтолгооны шатны тэмцээнд үзүүлсэн хамгийн сайн амжилтын нийлбэр дүнгээр гаргана.

5.5.3 Материаллаг баазаас шалтгаалан биеийн тамирын цогцолборт саадтай 100 метрийн гүйлтийн болон довтолгооны шатны тэмцээнд зориулагдсан гүйлтийн замтай халаалттай байранд тэмцээн явуулж болно. Олон улсын тэмцээнүүд нь тусгай комплекс буюу 2-4 уралдааны замтай спорт цогцолборт явагддаг. Саадтай 100 метрийн тэмцээн явуулах зам нь 115 метрээс доошгүй байх ёстой.

ЗУРГАА. ДЭЭД АМЖИЛТЫГ БҮРТГЭХ

6.1. Ерөнхий зүйл:

6.1.1. Гал унтраах техникийн олон төрөлт спортын холбооноос баталсан тэмцээний дүрмийн дагуу явагдсан албан ёсны олон улсын болон улс, бүсийн тэмцээн дээр үзүүлсэн спортын нэг болон бусад төрөлд байгаа дээд амжилтыг давтсан буюу шинэчлэн тогтоосон амжилтыг дээд амжилт гэж тооцно.

6.1.2. Гал унтраах техникийн олон төрөлт спортын тухайн төрөлд үнэмлэхүй дээд амжилтыг бүртгэж авна. Задгай талбайд болон зааланд үзүүлсэн амжилтыг тус тусад нь бүртгэж авна.

6.1.3. Спортын зэрэг, цолыг амжилт үзүүлсэн тамирчдад шууд олгоно.

6.1.4. Тамирчдад спортын зэргийн норматив биелүүлсэн тохиолдолд нөхөн олгоно.

6.2. Дээд амжилтыг бүртгэх дараалал:

6.2.1. Сонгон шалгаруулах болон шигшээ тэмцээнд мөн түүнчлэн хувийн амжилтаар зэрэглэл тогтооход авсан амжилт нь дээд амжилт байж болно. Гэхдээ энэ амжилт үзүүлсэн төрөл нь тухайн тэмцээний хөтөлбөрт орсон байх ёстой. Дүрмийн шаардлагуудыг хатуу баримтлан ГУТОТСпортын холбооноос зохион явагдсан урьдчилан төлөвлөөгүй болон баяр ёслол тэмдэглэлт өдрүүдэд зохиогдсон, олон улсын тэмцээн дээр үзүүлсэн амжилтыг дээд амжилт гэж бүртгэж авахыг зөвшөөрнө. Тэмцээн явагдах тухай болон тэмцээний хөтөлбөрийг тэмцээн явагдахаас 3-аас доошгүй хоногийн өмнө нийтэд зарлаж мэдээлсэн байх ба дээд амжилт үзүүлсэн төрөлд 3-аас цөөнгүй тамирчин оролцсон байх ёстой.

6.2.2. Олон улсын тэмцээний дээд амжилтыг цахим төхөөрөмжөөр бүртгэнэ. Гарааг зөвхөн буугаар гаргана.

6.2.3. Олон улсын чанартай тэмцээний дээд амжилтыг зөвхөн автоматчилагдсан хронометражаар бүртгэнэ. Автоматчилагдсан хронометражаар дээд амжилтыг бүртгэхдээ өмнөх оролцогчийн амжилтаас 0.01 секундээр давсан тохиолдолд бүртгэнэ.

6.2.4. Саадтай 100 метрийн зайн гүйлтэнд /2 төрөлтийг оролцуулан/ 2 м/сек-ээс дээш дундаж хурдтай салхины дагуу гүйж үзүүлсэн амжилтыг дээд амжилт гэж бүртгэж авахгүй. Дээд амжилтын үзүүлэлтүүдийг ерөнхий шүүгч болон түүний орлогч нэн даруй шалгана. Шалгахдаа дээд амжилт амжилт үзүүлсэн хэрэглэлүүдээс гадна гал унтраах хэрэгслийг шалгана.

6.2.5. Дээд амжилтыг бүртгэж шалгасан хэмжилтийн багаж нь (секундомер, эвхдэг метр болон хугацаа, зай, жинг хэмжих бусад төхөөрөмж) ГУТОТСпортын шаардлагуудыг хангасан байна.

6.2.6. Дараах нөхцлүүдийг хангасан бол дэлхийн болон европ, азийн аварга шалгаруулах тэмцээний дээд амжилтыг бүртгэж авна. Үүнд:

- тухайн тэмцээн нь гал сөнөөгч болон аврагчдын олон улсын спортын холбооны арга хэмжээний төлөвлөгөөнд орсон.

- гал сөнөөгч болон аврагчдын олон улсын спортын холбооноос ерөнхий шүүгчдийг баталсан

- гал сөнөөгч болон аврагчдын олон улсын спортын холбооноос шүүгчдийн бүрэлдэхүүнд тухайн тэмцээнийг хянах байцаагчийг томилсон.

- тэмцээнд гадаадын улс орнуудын 10-аас доошгүй шигшээ баг оролцсон

- тэмцээн нь гал сөнөөгч болон аврагчдын спортын дүрмийн дагуу явагдах бөгөөд тэмцээн эхлэхийн өмнө техник хэрэгслэл, хугацаа, хэмжих, багаж (секундомер)-ийг шаардагдах хэмжээнд байгаа эсэхийг шалгаж нотлож үйлдэнэ (тухайн тэмцээнд хэрэглэгдэх багаж, хэрэгсэл нь олон улсын тэмцээний дүрэмд заасан аюулгүй ажиллагааг хангасан байх)

• дэлхийн болон европ, азийн аварга шалгаруулах тэмцээний дээд амжилтыг задгай талбайд болон зааланд гэж ангилан бүртгэнэ;

6.3. Дээд амжилтыг баримтжуулах дараалал:

6.3.1. Бүх бүртгэгдсэн дээд амжилтыг шүүгчийн бүрэлдэхүүн материалыг шалгасны дараа батална.

6.3.2. Дээд амжилтыг батлахдаа олон улсын гал сөнөөгч, аврагчдын спортын холбооны баталсан загвараар нотломжийг 2 хувь бичнэ. Нотломжинд өмнөх дээд амжилтыг давтсан болон шинэчлэн тогтоосон амжилт бүрийг мөн 1 өдөрт 2 болон түүнээс дээш тооны тамирчин хэдэн удаа шинэчлэн тогтоосон болон давтсаныг оруулна. Нотломжинд:

а/ тэмцээний тухайн төрлийн тэмдэглэл.

б/ хугацааг хэмжих төхөөрөмжийг ашигласан бол барианы гэрэл зургийг хавсаргана.

Дээд амжилтын тухай материалуудыг тэмцээнийг зохион байгуулагчид дээд амжилт үзүүлсэн өдрөөс хойш 10 өдрийн дотор тэмцээний дүрмийн үнэн зөвийг шалгаад олон улсын болон улсын холбоонд өгнө.

6.3.3. Хэрэв нэг тэмцээн дээр болон сонгон шалгаруулах ба шигшээ тэмцээнд 2 болон түүнээс дээш тамирчин 1 ижил дээд амжилт үзүүлбэл, тэдний тэмцээнд эзэлсэн байраас хамаарахгүйгээр дээд амжилт тогтоосон гэж тооцно. Дээд амжилтын үзүүлэлтэд тамирчдын овог, нэрийг цагаан толгойн дэс дарааллаар бичнэ.

6.3.4. Хэрэв 1 гүйлтэн дээр 2 болон түүнээс олон тамирчин секундомерийн үзүүлэлтээр ижил амжилт үзүүлбэл бүгдийг нь дээд амжилт тогтоосон гэж тооцон дээд амжилтын хүснэгтэн дээр дээд амжилт тогтоосон гүйлтэнд нэрийн дарааллаар бичнэ.

6.3.5. Хэрэв календарийн 1 хоногт гал унтраах техникийн олон төрөлт спортын ямар нэг төрөлд нь янз бүрийн хотод хэд хэдэн тамирчин ижил дээд амжилт тогтоовол бүх тамирчдыг дээд амжилт тогтоосноор тооцно. Энэ тохиолдолд дээд амжилтын хүснэгтэн дээр үнэмлэхүй (астраномийн) цагаар тогтоосон дарааллаар овог, нэрийг нь бичнэ.

**ДОЛОО: ГАЛ УНТРААХ ТЕХНИКИЙН ОЛОН ТӨРӨЛТ
СПОРТЫН ЦОЛ, ЗЭРГИЙН НЭГДСЭН АНГИЛЛЫН НОРМ**

Хүснэгт

№	Спортын төрөл	ОУХМ	Спортын мастер	Дэд мастер	I зэрэг	II зэрэг	III зэрэг
1	Довтолгооны шат	14.20	14.80	15.60	17.80	19.00	19.80
2	Саадтай 100 метрийн тэмцээн	16.48	16.90	17.80	18.50	19.50	20.40
3	4x100 метрийн буухиа тэмцээн	57.50	59.30	61.50	67.50	70.00	71.00
4	Байлдааны тархалт /Шинэчлэгдсэн/	28.50	29.50	30.50	35.00	37.00	39.00

НАЙМ: ХӨТЛӨГДӨХ БАРИМТ БИЧИГ

Хавсралт №1

Тэмцээнд оролцох баг тамирчдын мэдүүлэг

№	Овог нэр	Төрсөн он	Анги байгууллага	Спортын зэрэг	Саадтай 100м	Довтолгооны шат	2 төрөлт	Буухиа	Байлдааны тархалт

Дасгалжуулагч:

Багийн ахлагч

Анги, байгууллагын дарга

гарын үсэг

гарын үсэг

Мэдүүлгээр оролцох бүх (оролцогч) тамирчид нь бие бялдарын хувьд бэлтгэл хангагдсан, эрүүл мэндийн үзлэгт орсон байх зайлшгүй шаардлагатай

Хавсралт №2

Гал унтраах техникийн олон төрөлт спортын довтолгооны шат, саадтай 100м-ийн уралдааны нэгдсэн дүн

Дараалал

Хаана явагдсан

Эхэлсэн

Он, сар, өдөр

Гүйлтийн зам

(цаг)

(мин)

цаг агаар

№	Овог нэр	Төрсөн он	Аймаг, хот	Амжилт			Эзэлсэн байр
				1-р	2-р	Дээд амжилт	

Тайлбар: Довтолгооны шат, саадтай 100м-ийн амжилтуудыг нэгтгэн 2 төрөлтийн амжилтыг протоколд тусгана. Ерөнхий шүүгч ба нарийн бичиг гарын үсэг зурсан байна.

Хавсралт № 3**ТЭМДЭГЛЭЛ**

Гал унтраах 4x100 метрийн буухиа уралдааны дүн

...он ... сар өдөр

Байр	Багийн нэр	Тамирчдын овог нэр	Амжилт	Авсан амжилт

Ерөнхий шүүгч:
Нарийн бичгийн шүүгч:

Хавсралт №4**ТЭМДЭГЛЭЛ**

Гал унтраах байлдааны тархалтын тэмцээний дүн

Байр	Багийн нэр	Тамирчдын овог, нэр	Амжилт		
			1	2	Авсан амжилт

Ерөнхий шүүгч:
Нарийн бичгийн шүүгч:

Хавсралт №5

Гал унтраах техникийн олон төрөлт спортын баг тамирчдын нэгдсэн амжилт, эзэлсэн байрны тэмдэглэл

Дараалал:
Хаана явагдсан:
Он, сар өдөр

Байр	Аймаг, хот	Тэмцээний төрөл										Нийлбэр амжилт	
		Саадтай 100 метрийн уралдаан		Довтолгооны шат		2 төрөлт		Буухиа уралдаан		Байлдааны тархалт			
		Цаг	Эзэлсэн байр	Цаг	Эзэлсэн байр	Цаг	Эзэлсэн байр	Цаг	Эзэлсэн байр	Цаг	Эзэлсэн байр		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	

Ерөнхий шүүгч
(шүүгчийн ангилал)

гарын үсэг

Ерөнхий нарийн бичиг
(шүүгчийн ангилал)

гарын үсэг

Хавсралт №6

Батлав
Тэмцээний ерөнхий шүүгч

.....гарын үсэг

20 оны-р сарын-ны өдөр

Гал унтраах техникийн олон төрөлт спортын дээд амжилт тогтоосон баримт

1. Он, сар, өдөр
2. Ямар төрөлд
3. Тэмцээн явагдсан газар
4. Ямар дасгал (төрөлд)
5. Хэн тогтоосон
 - а. овог, нэр
 - б. төрсөн он, сар
 - в. цол зэрэг
 - г. яс үндэс
 - д. гэрийн хаяг
6. Техникийн амжилт
7. Өмнө тогтоосон амжилтын он
Үзүүлсэн амжилт үр дүн
8. Тэмцээний амжилтыг тогтооход

№	Хэмжих багаж хэрэгслийн нэр	Хэмжих багаж хэрэгслийн номер	Шалгалт явуулах газар	Шалгалт явуулах байгууллага	Шалгалт явуулах он, сар, өдөр	Хэмжих багажийн үзүүлэлт

9. Цаг агаарын байдап, салхины чиглэл, хүч
10. Гүйлтийн замын хэмжээнүүд
11. Ямар гүйлтээр дээд амжилт тогтоосон
12. Тэмцээнийг батлан гаргасан дүрмийн дагуу явуулсан

Нарийн бичгийн дарга

Ахлах шүүгч

Гарааны шүүгч

Рекорд амжилт тогтоосноос хойш 10 өдрөөс хэтрүүлэлгүй бичиг баримтыг бүрдүүлсэн байх ёстой.

Хавсралт №7

Тэмцээний ерөнхий шүүгчийн дүгнэлтийн хэлбэр

Тэмцээний төрөл:
Явагдсан он, сар, өдөр:
Тэмцээн явагдсан газар:
Тэмцээнд оролцсон багийн тоо:
Тэмцээнд оролцсон тамирчдын тоо:
Багийн амжилт:
Төрөл тус бүрийн аварга шалгаруулах тэмцээнд эхний 3 байрт шалгарсан тамирчид:
Тэмцээний үед рекорд болон дээд амжилт тогтоосон байдал (хэн ямар амжилт тогтоосон) баримтжуулах:
Цаг агаар (температур, салхины хүч, хур тунадас, гэрэлтүүлэгч):
Мэдүүлэг болон (тэдгээрийг зөвшөөрөгдсөн эсэх):
Бэртэл, гэмтэл (бэртэл, гэмтэл авсан эсэх, авсан бол ямар арга хэмжээ авсан):
Хөгжөөн дэмжигчдийн тоо, тэдгээрт үзүүлсэн үйлчилгээний нэр төрөл:
Ерөнхий шүүгчийн зөвлөлийн ажлын арга барил, ёс суртахуун:
Тэмцээний дүнд өгсөн ерөнхий үнэлгээ санал хүсэлт:
Тэмцээний зөвлөлийн бүрэлдэхүүн ба тэдгээрийн ажилд өгсөн үнэлгээ

Хавсралт № 8

Гарааны шүүгчийн тэмдэглэл

Тэмцээний төрөл нэр


Гүйлт	Замын дугаар	Оролцогч тамирчны дугаар	Овог нэр	Оролцогч улс, клубын нэр	Тайлбар

Ерөнхий нарийн
бичгийн дарга






гарын үсэг







ЕС:ТЕХНИК ХЭРЭГСЛЭЛ, ЗАМЫН ХЭМЖЭЭС

4X100 метрийн буухиа тэмцээний техник хэрэгслэл, замын хэмжээ











Довтолгооны шатны тэмцээний цамхгийн стандарт, замын хэмжээ










Саадтай 100 метрийн тэмцээний техник хэрэгслэл, замын хэмжээ







4x100 метрийн буухиа тэмцээний байшин, тэвшний хэмжээ



Байлдааны таргалтын тэмцээний техник хэрэгслэл, замын хэмжээ

